МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,150.244... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.06.28. Лхагва. №124 (4738) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

ХОЁР ДАХЬ ШАТНЫ САНАЛ ХУРААЛТАД ИРГЭН БҮР ОРОЛЦОНО ГЭВ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ТА ИРЭХ САРЫН 1-НЭЭС ЯМАР ХУУЛЬ ХЭРЭГЖИЖ ЭХЛЭХИЙГ МЭДЭХ ҮҮ?

V нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +33
Шөнө +18



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Э.ЭРДЭНЭЖАМЪЯН:

МАХН гурав дахь шатны сонгуулийг зарлах хүртэл тэмцэх болно

Дэлгэрэнгүй ярилцлагыг VII нүүрнээс

## Баяр наадмаараа СОНГУУЛЬДАХ НЬ хэнд ашигтай вэ

Б.ӨНӨРТОГТОХ

Ардчилсан парламенттай болсон 26 жилийн түүхэнд анх удаа Төрийн тэргүүнээ сонгохоор дахин санал хураалт явуулах гэж байна. Энэ сарын 26-нд болсон Ерөнхийлөгчийн сонгуульд 1.978.298 нь сонгогчийн саналын хуудсанд бичүүлснээс 1.318.511 нь саналаа өгчээ. Үүнээс “сонголтгүй сонгууль” хэмээн эсэргүүцлээ илэрхийлсэн 18 мянган сонгогч байсан бол, 600 мянга гаруй сонгогч огт саналаа өгөөгүй юм. Долоо дахь удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн гурван нэр дэвшигчийн авсан санал гурван тал руу хуваагдсанаас үүдэж Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд заасны дагуу 50+1 гэсэн шалгуурт хүрч чадсангүй. Эхний шатны санал хураалтад АН-аас нэр дэвшигч Х.Баттулга илт давуу байж, өрсөлдөгч хоёроосоо 100 мянга гаруй хүний саналаа илүү байсан ч босго хувьдаа хүрч чадаагүй учраас ийн сонгууль хоёр шаттай болох нөхцөл бүрдлээ. Олон талаар эдийн засгийн хохирол учруулах энэхүү дахин санал хураалтыг хийхгүй байх боломж харамсалтай нь алга. Хуульд зааснаас нэр дэвшигч хоёр ямар ч сурталчилгаа байхгүйгээр 13 хоногийн дараа буюу ирэх долдугаар сарын 9-нд дахин өрсөлдөхөөр болж байна. Харин гадаадад ажиллаж амьдарч буй иргэд долдугаар сарын 4-нд дахин санал өгнө. Хэрвээ дахин санал хураалтад ирц хангалттай байж, нэр дэвшигчийн аль нэг нь 50+1 санал авч чадахгүй бол энэ сонгууль хүчингүй болж шинэ сонгууль болох нөхцөл байдал үүсч буй юм. Хэдэн төгрөг урсах, хэний буруу вэ гэдгийг дараа дараагийн нийтлэлээр хөндөх нь зөв биз. Харин энэ удаад дахин санал хураалт яагаад баяр наадмын өмнө, бүр болоогүй амралтын өдөр болж байгааг СЕХ-ноос асуумаар байна. Сонгуулийн тухай хуульд дахин санал хураалтыг 14 хоногийн дотор зарлана гэж заачихсан. Ажлын өдөр гэсэн хуулийн заалт ч бий.

Үргэлжлэл нь III нүүрт

Дугаарын 60 мөр

## Өргөст хэмх, улаан лоольны импортод цэг тавъя

Ч.ЧУЛУУН

Монгол Улс махнаас бусад хүнсний бараа бүтээгдэхүүнээ гаднаас импортолдог, түүгээр зогсохгүй хэн дуртай нь импортолж болдог, оруулж ирснийгээ хаа дуртай газраа зарж борлуулж, ашиг олдог цөөн улсын нэг байх. Эсвэл цорын ганц нь ч байж мэднэ. Тэр дундаа төмс, хүнсий ногоо импортолдог. Сахарын элсэн цөлд амьдардаг бол тийм байхаас ч өөр аргагүй. Гэтэл хөрс шороо минь онгон дагшнаараа шахам, хад чулуу багатай л бол хаана ч хамаагүй сонгины хар үр цацчихад хэдхэн хоноод л цоор нь цухуйх, нэг томоохон төмсийг тав хуваагаад булсан байхад ургаж л орхих тийм л оронд та бид амьдардаг атлаа төмс, хүнс, нарийн ногоогоо гаднаас импортлон тэрбум, тэрбумаар нь мөнгөө гадагш урсгасаар ирсэн. Өдгөө ч урсгасаар байгаа.

Үргэлжлэл нь III нүүрт

ДЭЛХИЙ

## “СИРИ ДАХИН ХИМИЙН ЗЭВСЭГ АШИГЛАХААР ЗЭХЭЖ БАЙНА”



Б.СУМЪЯА

АНУ-ын Цагаан ордноос мэдэгдэл хийж, “Сирийн Ерөнхийлөгч Башар ал Ассадын Засгийн газар энгийн иргэдийн эсрэг дахин химийн зэвсэг ашиглахаар зэхэж буйг илрүүлсэн” тухайгаа олон нийтэд мэдээллээ. АНУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газрын хэвлэлийн төлөөлөгч Шон Спайсерын хэлж буйгаар өнгөрсөн дөрөвдүгээр сарын 4-нд ашигласан химийн зэвсэглэлтэй яг адил зэвсгийг ашиглаж магадгүй аж.

Үргэлжлэл нь VI нүүрт

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

## Наадам, сонгууль хоёрыг зэрэг хийх нь ирц хүргэхгүй гэсэн башир арга гэв

Б.ДАВААХҮҮ

Монгол Улсын долоо дахь удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд хуулийн дагуу парламентад суудалтай намын төлөөлөл буюу МАН-аас УИХ-ын дарга М.Энхболд, АН-аас УИХ-ын гишүүн асан Х.Баттулга, МАХН-аас УИХ-ын гишүүн асан С.Ганбаатар нэр дэвшин өрсөлдсөн. Сонгуулийн санал хураалтын ажиллагаа орон даяар 07:00 цагт эхэлж, 22:00 цагт өндөрлөж, санал тооллогын ажиллагаа албан ёсоор эхэл Та ирэх сарын 1-нээс ямар хууль хэрэгжиж эхлэхийг мэдэх үү?эн бөгөөд өчигдөр үр дүн нь гарлаа. Гэвч нэр дэвшигчдийн хэн нь ч энэ удаагийн сонгуульд сонгогчдын талаас илүү хувийн санал авч чадаагүй учраас хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийн дунд шийдвэрлэх шатны санал хураалт явуулахаар болсон. Тус санал хураалтад АН-аас нэр дэвшигч Х.Баттулга, МАН-ын нэр дэвшигч М.Энхболд нар өрсөлдөх юм.

Үргэлжлэл нь IV нүүрт




### ХААН банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2345.00 | 2359.00 | ФУНТ | 2953.00 | 3044.00 |
| ЕВРО | 2617.00 | 2668.00 | РУБЛЬ | 39.00 | 40.90 |
| ИЕН | 21.00 | 21.25 | ЮАНЬ | 341.00 | 346.80 |

### Худалдаа хөгжлийн банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2345.00 | 2359.00 | ФУНТ | 2956.00 | 3029.00 |
| ЕВРО | 2600.00 | 2664.00 | РУБЛЬ | 38.92 | 41.76 |
| ИЕН | 20.78 | 21.32 | ЮАНЬ | 342.00 | 346.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## УИХ-ын гишүүн О.Баасанхүү СЕХ-нд шаардлага хүргүүлнэ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн үр дүнтэй холбогдуулан УИХ-ын гишүүн О.Баасанхүү СЕХ-нд шаардлага хүргүүлэх болжээ. Энэ удаагийн сонгуульд АН-аас нэр дэвшигч Х.Баттулга 517.478 санал, МАН-аас нэр дэвшигч М.Энхболд 411.748 санал, МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар 409.899 санал авсан. Хэдийгээр сонгуулийн ирц хүрсэн ч нэг нэр дэвшигчийн санал 50-аас дээш хувьд хүрээгүй тул дахин санал хураалтыг ирэх сарын 09-нд олонхийн санал авсан Х.Баттулга, М.Энхболд нарын дунд явуулах болсон юм. МАХН-ын удирдлагууд, гишүүд, дэмжигчид сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлсээр байгаа юм. Тиймээс УИХ-ын гишүүн О.Баасанхүү өнөөдөр 14.30 цагт СЕХ-нд очиж, МАХН-наас нэр дэвшигч С.Ганбаатарт санал өгсөн 409 мянган иргэний эрхийг хангах талаар шаардлага хүргүүлэх аж. Мөн МАХН-ын удирдлагууд 15.00 цагт сонгуулийн үр дүнгийн талаар намынхаа байр суурийг илэрхийлж, хэвлэлийн бага хурал хийсэн юм.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

# ХОЁР ДАХЬ ШАТНЫ САНАЛ ХУРААЛТАД ИРГЭН БҮР ОРОЛЦОНО ГЭВ

Н.БАТЗАЯА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн санал тооллогын мэдээллийг СЕХ орон даяар шууд дамжуулан хүргэсэн. Энэ сарын 26-ны 22:00 цагт албан ёсоор санал хураалт дууссанаар саналын тооллого явагдсан билээ. Гэвч зарим аймаг нэгдсэн мэдээгээ СЕХ-нд энэ сарын 27-ны өглөө 09:10 цагт ирүүлсэн юм. Үүнтэй холбогдуулан СЕХ хуралдаж Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит анхан шатны санал хураалтын дүнгийн тухай асуудлыг хэлэлцлээ. Сонгуулийн тухай хуулийн 146.1, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн анхан шатны санал хураалтад оролцож, саналаа өгсөн нийт 1357788 сонгогчдоос АН-аас нэр дэвшигч Х.Баттулга 517478 санал буюу 38.11 хувь, МАН-аас нэр дэвшигч М.Энхболд 411748 санал буюу 30.32 хувь, МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар 409899 санал буюу 30.19 хувийн санал авсан болохыг баталсан шийдвэр гаргажээ. Уг шийдвэртэй холбогдуулан СЕХ-ноос өчигдөр мэдээлэл хийлээ.

Энэ талаар СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн “Энэ удаагийн сонгуульд нийт 1.988.868 сонгогч бүртгүүлсэн ч 1.357.788 сонгогч саналаа өглөө. Сонгуулийн нэгдсэн дүнг СЕХ-ны хуралдаанаар авч хэлэлцээд ирц 50+1 хувьд хүрээгүй тул хоёр дахь шатны санал хураалтыг долдугаар сарын 09-нд явуулахаар шийдвэрлэлээ. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшигч Х.Баттулга 517478, МАН-аас нэр дэвшигч М.Энхболд 411748, МАХН-аас нэр дэвшигч 409899 санал авсан.

Анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчдын олонхийн санал авсан Х.Баттулга, М.Энхболд нарын дунд дахин санал хураалт явуулна. Мөн зарим аймгийн мэдээ удаж ирсэн асуудал гарсан. СЕХ-нд хамгийн сүүлийн мэдээ өглөөний 09:10 цагт ирсэн. Говь-Алтай аймгийн Цогт сумын 428 дэх хэсгийн хороо мэдээгээ дамжуулж чадахгүй саатсан. Үүнийг манай Мэдээлэл технологийн шуурхай багийнхан болон ТЕГ-аас шалгахад Юнител, Мобикомын кабелийн сүлжээг нь тасалчихсан байсныг тогтоосон. Энэ мэт хорлон сүйтгэх ажиллагаа явагдаж байна. Үүнийг цагдаа, тагнуулынхан баримтжуулан, шалгаж байна. Энэ удаагийн сонгуульд нэр дэвшигч М.Энхболд 411.748 сонгогч буюу нийт сонгогчдын 30.32 хувь, Х.Баттулга 517.478 санал буюу 38,11 хувь, МАХН С.Ганбаатар 409.899 санал буюу 30.19 хувийн санал авсан. Тиймээс Монгол Улсын Үндсэн хууль, Сонгуулийн тухай хуулийн дагуу нэр дэвшигчийн нэг нь ч олонхийн санал аваагүй тул хоёр дахь шатны санал хураалтыг явуулахаар шийдвэрлэлээ. СЕХ-ноос өнөөдрөөс эхлэн хоёр дахь шатны санал хураалтын бэлтгэл ажилдаа орж байна. Гадаадад буй иргэдийн саналыг долдугаар сарын 04-нд авна. Хоёр дахь шатны санал хураалтыг явуулахад 7.2 тэрбум төгрөг зарцуулах тооцоо гарсан. Үүнийг УИХ-аар батлуулж шийднэ. Мөн нэр дэвшигчид олонхийн саналыг авах буюу 50+1 санал авсан тохиолдолд сонгуулийн дүнг хүчинтэйд тооцно гэдгийг онцолъё. Дахин санал хураалт явуулахад ямар их зардал гардгийг та бүхэн харж байгаа болов уу. Энэ удаад сонгогчдын ирц дахин 50 хувьдаа хүрэхгүй бол сонгуулийг нэг мөсөн хүчингүй болгож, дахин сонгууль явуулах хуультай. Тиймээс сонгогчдыг дахин санал хураалтад идэвхтэй оролцохыг СЕХ-ноос уриалж байна” гэв. Мөн хоёр дахь шатны санал хураалтад иргэн бүр оролцох гэнэ. Тиймээс иргэдийг дахин санал хураалтад идэвхтэй оролцохыг СЕХ-оос уриалж байлаа. Энэ үеэр сэтгүүлчид асуулт асууж, хариулт авсаныг дэлгэрэнгүй хүргэе.

**-Баян-Өлгий аймгийн мэдээлэл хүлээгдэж ирсэн. Энэ ямар шалтгаантай вэ?**

-Хуульд зааснаар сонгуулийн санал хураалт дуусмагц нэгдсэн дүнг ажиглагчид хэвлэж өгч, дамжуулдаг. Үүний дараа нь техникийн тооллого хийхээр зохицуулсан байдаг. Баян-Өлгий аймагт техникийн тооллогоо хийснийхээ дараа автомат машины дүнтэй санал хураалтаа тулгасан юм билээ. Тулгасан дүн мэдээгээ манайд дамжуулахаар шийдвэрлэсэн. Үүнд бид хүлээцтэй хандсан.

**-МАХН-ын дэмжигчид багагүй шуугиан дэгдээсэн. Үүний талаар тайлбарлагүй юу?**

-СЕХ-ны байранд энэ сарын 26-нд гурван намын удирдлага болон төлөөлөл ирж, бидэнтэй уулзсан. Санал хураалтын нэгдсэн дүнг нэр дэвшигчид ажиглагч нараараа дамжуулж урьдчилан мэдсэн байсан. Өөрөөр хэлбэл, манай СЕХ-ны мэдээллээс өмнө намууд сонгуулийн дүнг мэдсэн гэсэн үг. Тийм учраас дахин санал хураалт хэзээ болох, шийдвэрээ хэзээ гаргах тухай асуудлаар бидэнтэй уулзаж, хариулт авсан. МАХН-аас сонгуулийн дүнтэй холбогдуулж эсэргүүцэл илэрхийлсэн.

**-Дахин санал хураалтад хэчнээн төгрөгийн төсөв шаардагдах вэ?**

-СЕХ-ны хурлаар хэлэлцсэний үр дүнд хоёр дахь шатны санал хураалтад нийт 7.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тооцоолloo. Уг асуудлыг Засгийн газарт тавьж, шаардагдах төсвийг гаргуулах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн.

**-Хоёр дахь шатны санал хураалтад 50+1 хуулийн заалт үйлчлэх үү. Саналаа өгсөн иргэд дахин санал өгөх үү?**

-Би хэвлэлийн хурлын үеэр энэ удаагийн сонгуульд хоёр олонх гэсэн үг бий гэж хэлсэн. Нэгдүгээрт, нэр дэвшигчид нийт саналаа өгсөн сонгогчдын олонхийн саналыг авсан байх ёстой. Хоёрдугаарт, нийт сонгуульд оролцогчдын ирц 50 хувиас дээш байх ёстой.

**-Энэ удаагийн сонгуульд ямар нэгэн байдлаар будилаантаагүй гэж ойлгож болох уу?**

-Одоогийн байдлаар ямар нэгэн гомдол, санал ирээгүй байна. Техникийн тооллогыг 50 хувьд нь хийсэн. Гэхдээ ямар нэгэн зөрүү, гомдол гараагүй.

**-Зарим хувийн байгууллагууд ажилчдынхаа сонгох эрхээ эдлэх боломжийг хангаж өгөөгүй гэх асуудал гарч байсан. Үүнд ямар арга хэмжээ авч ажилласан бэ?**

-Хувийн хэвшил, олон хоногийн ээлжийн үйл ажиллагаатай байгууллагуудад зөвлөмж хүргэсэн. Зөвлөмжид нийт ажилчдынхаа сонгох эрхийг хангаж, саналаа өгөх цагийг гаргаж өгөхийг тусгасан. Ихэнх байгууллагууд манай зөвлөмжийг биелүүлж ажилласан. Энэ төрлийн тохиолдол гарсан зарим нэг байгууллага байж болзошгүй. Энэ талаар тодорхой хаягтай гомдол, санал ирээгүй байна.

**-Дахин санал хураалт наадмын өмнө таарч байгаа юм байна. Иргэд хөдөө аялал зугаалганд явж, ирц бүрдэхгүй байх вий гэх асуудал байна?**

-Тийм учраас иргэддээ дахин санал хураалтдаа идэвхтэй оролцохыг уриалж байна. Дахин санал хураах, дахин сонгуулийг зохион байгуулахад хэр хэмжээний их зардал гардагийг харлаа. Хэрвээ дахин санал хураалтаар хэн нь ч олонхийн санал аваагүй, сонгогчдын ирц 50-иас дээш хувьд хүрээгүй тохиолдолд сонгууль бүхэлдээ хүчингүй болдог хуулийн заалттай. Үүний дараа УИХ дахин сонгууль зарлана. Сонгуулийг дахин зохион байгуулна гэдэг зардал, хүн хүч, цаг хугацаа шаардсан ажил болно. Тиймээс иргэддээ дахин санал хураалтад идэвхтэй оролцохыг уриалж байна.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Хоёр дахь шатны санал хураалтыг ажлын өдөр явуулахыг СЕХ-ноос шаардлаа


АРДЧИЛСАН НАМ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1 дүгээр хороо, Соёл амралтын хүрээлэн
Гэндэнгийн гудамж-16, 4,5 давхарт Ардчиллын өргөө
Утас 11-339966, Факс (976-11) 339966
E-mail:www.@demparty.mn, http://www.@demparty.mn
2017.06.27 № 01/207
-ны № танай

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД

Хоёр дахь санал хураалт явуулах өдрийг товлох талаар шаардлага хүргүүлэх тухай

Сонгуулийн Ерөнхий хорооны удирдлагууд 2017 оны 6 дугаар сарын 27 ны өдөр Монгол улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн дүнг танилцуулж 2 дахь шатны санал хураалтын товыг танилцуулахдаа Сонгуулийн хуулиар зохицуулаагүй, Сонгуулийн Ерөнхий хороонд олгогдоогүй үндэслэлээр **2017 оны 7 дугаар сарын 9 ны өдөр гэж** санал хураалтын товыг гаргасан байна. Хуульд нийцээгүй, үндэслэлгүй товын талаар доорхи тайлбарыг гаргаж байна. Үүнд:

1. Сонгуулийн тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.2-д зааснаар Ерөнхийлөгчийн сонгуульд 2 дахь санал хураалтыг анхны санал авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор зарлан, зохион байгуулна гэсэн зохицуулалттай байгаа ба энэ нь 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдрөөс 2017 оны 7 дугаар сарын 10 хүртэлх хугацааг ойлгож байгаа билээ.

2. Сонгуулийн төв байгууллагад 2 дахь санал хураалтыг санал авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор зохион байгуулах хэдий боловч иргэд сонгогчдын амралтын өдөр, мөн Монгол төрийн баяр наадмыг аймаг, нийслэл бүх нийтээрээ тэмдэглэн өнгөрүүлдэг өдөр болох 2017 оны 7 дугаар сарын 9 нд давхцуулан санал хураалт явуулах зохицуулалт, эрх байхгүй болно.

Иймд Ерөнхийлөгчийн сонгуулийн 2 дахь санал хураалтын хугацааг зохицуулсан өдрийг товлохдоо Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.4-д заасан аль нэг ажлын өдөр гэсэн зохицуулалтаар хууль хэрэглэж Ерөнхийлөгчийн Сонгуулийн 2 дахь санал хураалтын товыг аль нэг ажлын өдрөөр буюу 2017 оны 7 дугаар сарын 6 ны өдрийн Пүрэв гаригт тогтоож шийдвэрлэхийг шаардаж байна.

ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ц.ТУВААН

Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Туваан Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатны санал хураалтыг хуулийн дагуу ажлын өдөр товлохыг СЕХ-ноос шаардлаа.Монгол Улсын долоо дахь удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль энэ сарын 26-ны өдөр болж, хуулийн дагуу парламентад суудалтай буюу МАН, АН, МАХН гэсэн гурван намын нэр дэвшигч дараагийн төрийн тэргүүн болохоор өрсөлдсөн билээ. Гэвч нэр дэвшигчдийн хэн нь ч нийт сонгогчдын талаас илүү хувийн санал авч чадаагүй учир, түүхэндээ анх удаагаа шийдвэрлэх шатны санал хураалтыг явуулахаар болсон.Харин СЕХ-ноос өнөөдөр мэдэгдэл хийж, хоёр дахь шатны санал хураалтыг долдугаар сарын 9-ний өдөр буюу ням гарагт товлож буйгаа мэдэгдсэн юм. Гэвч энэ тов нь хуульд нийцээгүй, үндэслэлгүй гэсэн шалтгаанаар АН-аас СЕХ-нд шаардлага хүргүүлэн амралтын өдөр биш, ажлын өдөр товлох шаардлагыг хүргүүллээ. Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.4-д аль нэг ажлын өдөр санал хураалтыг товлоно гэж заасан байдаг байна. Энэ дагуу хоёр дахь санал хураалтыг ажлын өдөр буюу долдугаар сарын 6-ны пүрэв гарагт товлохыг АН-аас шаардаж буй аж.

## ОХУ шүлхийн вакцин нийлүүлэхээр болжээ

ОХУ-ын Санкт-Петербург хотноо энэ сарын 1-3-ны өдрүүдэд Петербургийн олон улсын эдийн засгийн форум болсон билээ. Энэхүү форумд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат оролцож, тодорхой гэрээ хэлэлцээрүүдийг байгуулсан юм. Тэгвэл “Монгол Улсад ОХУ-аас хүмүүнлэгийн тусламж үзүүлэх тухай хэлэлцээр”-ийн дагуу тус улсаас малын шүлхий өвчний эсрэг 4.1 сая тун вакциныг Монгол Улсад 2017 оны долдугаар сарын II хагаст багтаан нийлүүлэх шийдвэрийг гаргасан байна. Түүнчлэн тохиролцсоны дагуу ОХУ-аас хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй зээлээр нийлүүлэх шийдвэрийг Оросын тал гаргаж, холбогдох ажлыг ирэх сард багтаан гүйцэтгэхээр болжээ. Хоёр орны хөдөө аж ахуйн салбарын хамтынажиллагаандчухалхувь нэмэр оруулах уг шийдвэрийг ОХУ-ын Хөдөө аж ахуйн яамны Олон улсын хамтын ажиллагааны газрын захирал О.В.Гаршина энэ сарын 23-ны өдөр тус Элчин сайдын яамны байранд хүрэлцэн ирж, Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б.Дэлгэрмаад гардуулсан ажээ.

# ҮЗЭЛ БОДОЛ



# Баяр наадмаараа СОНГУУЛЬДАХ НЬ ХЭНД АШИГТАЙ ВЭ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэгэхээр долдугаар сарын 10-наас өмнөх аль ч өдөр зарлах боломжтой гэсэн үг. Хүмүүсийн амралт эхлээгүй, ажилтай байхад санал авах тусмаа л ирц хангалттай бүрдэж, шинээр сонгууль хийхгүй, хэдэн арван тэрбум төгрөг салхинд хийсгэхгүй зохион байгуулах боломжтой. Үүнийг олон жил СЕХ-ны үйл ажиллагааг удирдсан Ч.Содномцэрэн дарга юу юунаас илүү мэдэж байх учиртайсан. Эсвэл мэдсэн ч мэдэн будлихыг хүсэв үү. Мэдээж санал өгөх хуудас дахин хэвлэх, машиныг шинээр програмчлах гэх мэтээр хугацаа шаардах ч үгүй ядахдаа ажлын өдөр зохион байгуулаад, ажилдаа ирэхдээ цагаан хуудсаа харуулж нэг өдрийн цалингаа бодуулах гэх мэтээр хариуцлагын асуудлыг ярьвал болохгүй гэх зүйл огтхон ч алга. Амралтын өдөр хийх тусмаа л иргэд агаар салхинд гарч амрахыг урьтал болгодог. Цаашлаад баяр наадам эхлэхийн өмнөх өдөр нийслэлд үлдэх хүн байхгүй гэдгийг олон жил сонгууль хийсэн улс төрийн намууд мэдэж баймаарсан. Долдугаар сарын 9-нд тухайлбал, нэлээд олон аймаг, сумын улсын баяр наадам товлогдчихсон байжээ. Хуушуур хийх зөвшөөрлөө авчихсан, бараа бүтээгдэхүүн зарах иргэд ч ажлаа товлочихсон байж. Гэтэл дахин санал хураалтаас болж нэлээд олон аймгийн наадам цуцлагдаж байгаа бололтой. Төрийн буруу шийдвэрээс болж нөгөө талд асар их мөнгө хий дэмий салхинд үрэгдэх нь. Мөн энэ өдөр нийслэлийн залуусын хүсэн хүлээдэг амьд хөгжмийн "Playtime" наадам хотоос зайдуухан болох гэнэ лээ. Сонгуулийн насны хамгийн идэвхгүй хэсэг бүлэг бүгдээрээ энэ наадмыг үзэхээр явна. Тэр тохиолдолд дахиад л санал хураалтын ирц хүрэхгүй болж шинээр сонгууль зохион байгуулахаас өөр аргагүйд хүрнэ. Эсвэл мөн л олон өдрийн бэлтгэл, ажлыг нь хойш татуулж цуцлахад хүрэх биз. Нэгхэн хоногийн дараа наадам эхлэх гэж байхад сонгууль өгөөд явах хүн тэр болгон олдохгүй гэх мэтээр наадмын өмнөх сонгууль бүх талаараа буруу тийш эргэх нь ээ. Ерөөс улс төрийн намуудын олон жилийн түүхэнд баяр наадмаар далимдуулж болохгүй бүтэхгүй бүхнийг хийж, хор хутгаж ирсэн түүх бий. Ард түмний анхаарал наадам цэнгээн, амарч зугаалахад чиглэсэн үеийг далимдуулж УИХ-аар дандаа болохгүй, бүтэхгүй хуулиа баталж байсан жишээ олныг нэрлэж болно. Тиймээс энэ удаад ч наадмаар далимдуулж сонгуулийн луйвар хийх вий гэсэн болгоомжлол ч улс төрийн намууд болон улстөрчдөд байгаа юм билээ. Тухайлбал, УИХ-ын дарга асан З.Энхболд "СЕХ өглөө 09:00 цагаас хуралдаж, түүхэнд байгаагүй буруу шийдвэр гаргасан байна. Яагаад гэвэл, 8, 9-ний өдөр наадам эхэлчихдэг. Сур харваа эхэлчихдэг, дааганы уралдаан болдгийг та бүхэн мэдэж байгаа байх. Бүх аймгийн наадам 8, 9-ний өдөр болохоор төлөвлөгдөөд, шийдвэр нь гарчихсан байна. Монгол Улс сонгууль явуулж эхэлснээс хойш түүхэндээ анх удаа наадмын өдөр саналт хураалт хийх балмад шийдвэрийг СЕХ гаргасныг эсэргүүцэж байна. АН Сонгуулийн хуулийн 16.2-т зааснаар ажлын өдөр явуулахыг шаардана. СЕХ аль дуртай өдрөө сонгууль явуулах эрх байхгүй. 16.2-оор сонгуулиуд аль нэг ажлын өдөр болдог. Ээлжит бус бусад сонгууль, дахин санал хураалтыг ч гэсэн 16.2-т нийцүүлнэ явуулна гэж Сонгуулийн хуулийн 20.3-т заасан байгаа. Тийм учраас наадмын өдөр явуулах гэж байгаа дахин санал хураалтаа нэн даруй, өнөөдөр өөрчил. СЕХ-ныхон МАН-ынханд долигнож болно. Гэхдээ ингэж хуулиа зөрчиж битгий долигно. Ялангуяа Болдсайхан гэдэг нөхрийг энэ шийдвэрт оролцуулж болохгүй. Ашиг сонирхлын зөрчилтэй хүн. Тэр хүнээ хол байлгаж байж шийдвэрээ гаргаарай. Ажлын өдөр сонгууль явуулах шийдвэрийг би хэлээд байгаа юм биш. Хуульдаа тийм байна. Тийм болохоор АН-ынхан ажлын өдөр дахин хураалтыг явуулахыг албан бичгээр мэдэгдэнэ, шаардана" гэсэн мэдэгдэл хийлээ. Эхний шатны санал хураалтад нэр дэвшигч нь ялсан АН-ын зүгээс ч ийм мэдэгдэл хийсэн. Гэтэл баяр наадамтай зэрэгцэн хийхийг ганцхан МАН дэмжээд сууж байгаа нь эрхгүй хар төрүүлж буй юм. Тэдэнд сонгуулийг наадамтай давхцуулах ямар нэгэн ашиг сонирхол байхыг үгүйсгэх арга алга. Хуульдаа ажлын өдөр хийнэ гэж тусгачихсан атал наадмын өмнө хийж долоон тэрбум төгрөгийг салхинд хийсгэх хүсэл улс орноо боддог улс төрийн нам эвсэл, улстөрчдөөс гарч байгаа гэхээр л дахин санал хураалтад итгэх итгэл төрөхгүй байгаа юм. Хэдийгээр дахин санал хураалт хүртэл улс төрийн намууд болон нэр дэвшигчид сурталчилгаа хийх эрхгүй ч явган сурталчилгааг хориогүй. Тэр тусмаа хуульгүй юм шиг орон зай бол сошиал орчин. Тэнд нэгнээ гүтгэсэн харлуулсан, доромжилсон, улстөрчдийн фанатуудын нэгнээ үзэн ядсан хийрхэл ихсэх тусмаа л ирцэд улам бүр л нөлөөлнө. Залуус залхаж эхэлнэ. Дахиад л хэдхэн ахмадууд саналаа өгсөн нэр зүүж, хэдэн арван цэцэрлэгийн мөнгийг хийх дэмий салхинд хийсгэх болчихоод байна, эрх баригчид аа. Ерөөс ард түмэн нь наадаж цэнгэж байхад төрийн тэргүүн, төр засгийн удирдлага сонго хэмээн тулган шаарддаг улс манайхаас өөр байхгүй гэдэгт мөрийцсөн ч бэлэн байна. Ийм л мэргэн шийдвэр гаргадаг төртэй учраас иргэдийн итгэл жилээс жилд буурч байгааг буруутгах аргагүй биз ээ.

> ...Гэтэл баяр наадамтай зэрэгцэн хийхийг ганцхан МАН дэмжээд сууж байгаа нь эрхгүй хар төрүүлж буй юм. Тэдэнд сонгуулийг наадамтай давхцуулах ямар нэгэн ашиг сонирхол байхыг үгүйсгэх арга алга. Хуульдаа ажлын өдөр хийнэ гэж тусгачихсан атал наадмын өмнө хийж долоон тэрбум төгрөгийг салхинд хийсгэх хүсэл улс орноо боддог улс төрийн нам эвсэл, улстөрчдөөс гарч байгаа гэхээр л дахин санал хураалтад итгэх итгэл төрөхгүй байгаа юм...

Дугаарын 60 мөр

## Өргөст хэмх, улаан лоольны импортод цэг тавъя

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Уг нь бидэнд тэгэх шаардлага байхгүй. Ногоочдын маань тарьсан байцаа, сонгино мэтийн жилдээ хоёр хураан авдаг хүнсний ногоонууд эхнээсээ болж, наадмын маргаашаас л зах зээлд нийлүүлэгддэг. Дээр нь 370 аж ахуйн нэгж төмс, хүнсний ногоо тариалдаг. Мөн хангайн бүсийн ихэнх аймгийн иргэд хашаандаа өөрийн хэрэгцээг хангахуйц ногоог тариалдаг. Түүнчлэн өнгөрсөн намар 165.2 мянган тонн төмс, 72.7 мянган тонн хүнсий ногоо хураан авсан бол өнөөдрийн байдлаар газар тариалангийн бүс нутаг гэгддэг Сэлэнгэ аймаг 85 мянган га талбайд төмс, Орхон аймаг 380 мянган га-д төмс, 348 мянган га-д хүнсний ногоо тариалсан байх жишээтэй. Нарийн ногооны тухайд 150 гаруй аж ахуйн нэгж хүлэмжийн аж ахуй эрхлэн өргөст хэмх, улаан лооль, сармис, бууцай, цэцэгт байцаа, яншуй, шанцай мэтийн нарийн ногоо тариалаад зогсохгүй гүзээлзгэнэ болоод жимс жимсгэнийг тариалах болсон. Хүлэмжид тариалсан өргөст хэмх, улаан лооль эхнээсээ зах зээлд худалдаалагдаад эхэлсэн ч үнэ нь өндөр, олдоц нь ховор байгаа учраас иргэд мөнөөх л импортын хүнсний ногоогоо хэрэглэсээр байгаа юм. Үнэн хэрэгтээ өнгөрсөн намар хураасан, хатуу хэлэхэд үхэр ч тоож идэхгүй болтлоо илүүдээд байсан төмс, хүнсий ногоогоо зөв хадгалж, зөв тээвэрлэх аваас гурван сая иргэний хэрэгцээг өлхөн хангачих байлтай. Гэтэл үгүй юм аа. Зооринд хадгалсан ногооны нөөц багасах тусам импортлогчдын царайд баярын мишээл тодрон, урд хөршийнхний химийн бордоогоор бордож бордож ургуулсан, эсийн өөрчлөлттэй хүнсний ногоог тонн тонноор нь оруулж ирэн зах зээлд шахах нь бий. Улсын их баяр наадам дөхөх тусам хэрэглээ нь нэмэгддэг лууван, төмс, сонгино, салатны навч, улаан лооль, өргөст хэмхний үнэ тэнгэрт хадаж, кг төмс 2100-2500 төг болтлоо өсдөг. Үүнээс анзаарахад, ногоочид л хамгийн сайхан амьдармаар. Гэтэл бодит байдал дээр эсрэгээрээ. Хаврын хавсарганаар тариалалтдаа гарсан ногоочид зунжингаа халуун наранд шарагдан зэрлэгтэй ноцолдсоор намрын сартай золгон, нуруугаа тэнийлгэх үед импортлогчид маш хямд өртөг бүхий ногоог импортоор оруулж ирэх эс бөгөөс газар дээрээс нь байцааг тонн-ыг нь 5-8 мянган төгрөгөөр худалдаж авч, тэдний хөдөлмөрийг үнэгүйдүүлж орхидог. Тэгсэн мөртөө нийслэлийн иргэдэд наймдугаар сарын нэгнээс есдүгээр сарын 10 хүртэл тэнгэрт хадсан үнээр, тодруулбал, кг байцаа 3000, төмс 1800, монгол үрийн сонгино 2500, лууван 2200 төгрөгөөр худалдаалах жишээний. Намрын дунд сар гараад ч Улаанбаатар хотод ногооны үнэ 500 төгрөгөөр буурдаг атлаа газар тариалангийн бүс нутагт кг 250-500 болдог гэж байгаа. Өнгөрсөн жил хур их орсны улмаас төмс төдийлөн ургаагүйн улмаас зах зээлд төмсний үнэ тэнгэрт хадсан хэвээр зуны дунд сартай золгоод байгаа. Наймаачид ч эл байдлыг далимдуулан буриад шар төмс, хятад шар төмсийг маш их хэмжээгээр импортлон зах зээл дээр шороонд өнхрүүлэн гадна талыг нь халтартуулж аваад "жавхлантын", "борнуурын" , "шаамарын", "орхоны" гэхчилэн монгол аж ахуйн нэгжүүдийн нэрийг худалдаалдаг нь нууц биш. Иргэд ч түүнийг нь мэдсээр байж авч идсээр. Учир иймээс холбогдох яамныхан эрт ургацын ногоо зах зээлд нийлүүлэгдэхтэй зэрэгцээд импортын төмс, хүнсний ногоонд хориг тавьдаг болбол яасан юм бэ. Эдийн засаг хямарч, үрийн зээлээ төлж чадахгүйд хүрээд байгаа ногоочдын маань амьдрал жаахан ч болов сэв хийгээд авна гэдгийг надаар хэлүүлэлтгүй мэддэг байлтай. Импортын хүнсний ногоонд цэг тавьж, үндэсний ногоочдоо төр бодлогоор дэмжээд өгвөл ногоочдын төдийгүй бидний ч амьдрал өндийнө дөө.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# УЛС ТӨР

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

# НААДАМ, СОНГУУЛЬ ХОЁРЫГ ЗЭРЭГ ХИЙХ НЬ ИРЦ ХҮРГЭХГҮЙ ГЭСЭН БАШИР АРГА ГЭВ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

СЕХ-ноос хоёр дахь шатны санал хураалтын товыг долдугаар сарын 9-ний өдөр явуулахаар зарласан. Гэвч, АН-аас уг санал хураалтыг амралтын өдөр бус, ажлын өдөр буюу долдугаар сарын 6-ны пүрэв гарагт явуулах шаардлагыг СЕХ-нд хүргүүлээд байна. Түүнчлэн, Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн гурван намын төлөөлөл өчигдөр ээлж дараалан хэвлэлийн бага хурал хийж, сонгуулийн үйл явц, цаг үеийн асуудлаар мэдээлэл хийсэн юм. Ингээд тэдгээрийг тоймлон хүргэж байна.

Цаг үеийн асуудлаар Ардчилсан нам Төрийн ордонд 17:00 цагт хэвлэлийн хурал зарлалаа. Хэвлэлийн бага хуралд АН-ын дарга С.Эрдэнэ, УИХ-ын дэд дарга Я.Санжмятав, нэр дэвшигч Х.Баттулга нар оролцлоо. Хурлын эхэнд Ардчилсан намын дарга С.Эрдэнэ "Энэ удаагийн сонгууль тийм амар байсангүй. Маш олон шалгуур хүндрэлүүдийг бид амжилттайгаар даван гарч сонгуулийн ард гарлаа. Үнэхээр хүч тэнцвэргүй сонгууль болсон гэдгийг онцолж хэлмээр байна. Учир нь эрх баригчид өөрсдөд нь олгогдсон төрийн эрх мэдлийг хууль бусаар ашиглах замаар сонгуулийг будлиантуулах, өрсөлдөгч улстөрийн намууддаа дарамт шахалт үзүүлж, айлган сүрдүүлж байсан. Мөн төрийн хүчний байгууллагуудыг ашиглан өрсөлдөгч намынхаа дотоод үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд нь хүндрэл учруулах зэрэг олон үйл явц боллоо. Хамгийн сүүлийн жишээ гэхэд л сонгуулийн үйл явц шударга болж чадсан гэдэгт эргэлзэж байгаа. Учир нь сүүлдээ цөөн тооны сонгуулийн хэсгийн саналыг зориудаар эсвэл зориуд бус нь мэдэгдэхгүй байдлаар шөнөжингөө барьж, илт харсаар байтал эрх баригч намын хүний саналын тоо маш хурдтай өссөн. Харин нөгөө хоёр намын нэр дэвшигчдийн санал маш удаашралтай өсч байсан. Энэ бүгдийг харж байхад зориуд зохион байгуулалттай үйлдэл байх магадлал харагдаж байгаа. Энэ удаагийн сонгуульд Монголын ард түмний 40 орчим хувь нь АН-аас нэр дэвшигч



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Х.Баттулгын төлөө саналаа өгсөн. Нийт санал өгсөн иргэд тусгаар тогтнол, ирээдүйнхээ сайн сайхныхаа төлөө сонголтоо хийсэн. Маш их баярлалаа, сонгогчиддоо" гэлээ. Мөн сонгогчдын саналыг худалдан авахаар сүлжээ бий болгож ажилласан зэрэг хууль зөрчсөн үйлдлийг холбогдох байгууллагуудад нь шалгуулахаар хандсан, албан ёсны хариуг шаардах болно гэдгээ мэдэгдлээ. Түүнчлэн, Сонгуулийн ерөнхий хороонд санал хураалтын эцсийн дүн болон МАХН, МАН-ын нэр дэвшигчдийн саналын зөрүүний талаар сонгогчдод үнэн зөв мэдээлэл өгч, эргэлзээг тайлахыг уриалсан юм. Энэ үеэр АН-ын сонгуулийн штабын ерөнхий менежер, УИХ-ын гишүүн Я.Санжмятав "Монголоо ялуулахын төлөө бидэнтэй хамт байсан сонгогчиддоо талархал дэвшүүлж байна. Энэ удаагийн сонгууль хоёр шаттай учраас өмнө нь өгсөн саналаа бататгах, саналаа өгөөгүй сонгогчид тэнцвэргүй байгаа нөхцлийг тэнцвэржүүлэхийн тулд Ардчилсан намаас нэр дэвшигч Х.Баттулгыг дэмжихийг уриалж байна. Та бүхний нэг ч гэсэн санал үнэтэй шүү. Тиймээс АН-аас нэр дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд та бүхний дэмжлэг хэрэгтэй байна. Монгол төрийн тэргүүнийг сонгох чухал сонголтод хуулийн байгууллага эрх тэгш ажиллаж, хуулийн хүрээнд ажиллахыг хүсч байна" хэмээлээ.

Харин нэр дэвшигч Х.Баттулга "Сонгууль хүнд болсон. Миний хувьд өрсөлдөгч нараасаа 110 мянга гаруй саналаар илүү байсан ч хуулийн дагуу дахин санал хураалт явагдахаар боллоо. Сонгогчид баялаг хулгайлагчид, оффшорчдын эсрэг, Монголын төрийг худалдсан 60 тэрбумын луйврын эсрэг саналаа өгсөн гэж бодож байна. Дахин санал хураалтыг Үндэсний их баяр наадамтай хамт зохион байгуулж байгаа нь харамсалтай байна. Наадам, сонгууль хоёрыг зэрэг хийх нь ирц хүргэхгүй гэсэн башир арга. Ирц хүрлээ гэхэд өөрийнхөө хүнийг ялуулах гэсэн оролдлого гэж харж байна. АН-аас нэр дэвшигч миний бие олонх болсон гэдгээ зарлах таатай байна. Нийт монголчуудынхаа итгэлийг алдахгүй гэдгээ амлаж байна " гэсэн юм.

Дашрамд дурьдахад, Ардчилсан намаас өчигдөр Сонгуулийн ерөнхий хороонд албан тоот хүргүүлсэн юм. Тус албан тоотод хоёр дахь шатны санал хураалт болох өдрийг өөрчлөхийг тусгасан аж. Энэ талаар АН-ын дарга С.Эрдэнэ "Долдугаар сарын 9-нд ням гараг таарч байгаа. Тэгэхээр бид долдугаар сарын 6, 7-ны ажлын өдөр санал хураалтыг явуулах хэрэгтэй гэсэн байр суурьтай байгаа. Хоёрдугаарт, ажлын өдөр санал хураалт явуулах талаар Сонгуулийн тухай хуулийн заалт бий. Бүх шатны буюу Ерөнхийлөгчийн болон парламентын сонгуулийг ажлын өдөр товлож, тухайн өдрийг амралтын өдөр болгон санал хураалт явуулах зохицуулалт хийсэн байгаа. Тэгэхээр ням гарагт, мөн наадмын эхний өдөр товлосон нь ирцийг хүргэхгүй байх, сонгуулийн хүчингүй болгох далд санаа агуулж байж болзошгүй байгаа учраас СЕХ-г хуулиараа хүлээсэн үүргийнхээ дагуу хуулийн хугацаанд зөв товлооч гэсэн шаардлагыг хүргүүлж байгаа юм" гэх тайлбарыг өглөө. Үүний дараа сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өгсөн юм.

**-Долдугаар сарын 9 гэдэг та бүгдийн хэлснээр амралт зугаалгын үе. УИХ-аас Чиглэл гаргаад сонгогчдын ирцийн сайжруулах талаар ямар нэг алхам хийх ёстой юу?**

**С.Эрдэнэ:** УИХ-аас сонгуулийн ирцийг нэмэгдүүлэх чиглэлээр ямар нэг арга хэмжээ авах боломж маш бага. Авсан ч үр дүн гарахгүй гэж харж байна. Яагаад вэ гэвэл, аймаг, орон нутагт Үндэсний их баяр наадмын үйл ажиллагаа давхцана. Үндэсний сурын харваа эхэлчихсэн байх юм. Энэ бол зориуд ирц бүрдүүлэхгүй байх гэсэн бохир арга гэж харж байгаа. Ямар ч арга хэмжээ авсан сонгуулийн ирцийг нэмэгдүүлэх боломж бага.

**-Энэ хугацаанд МАХН-тай хамтран ажиллах талаар яриа, хэлэлцээр хийх болов уу?**

**С.Эрдэнэ:** Бид ямар нэг улс төрийн намтай яриа хэлэлцээр хийгээгүй. Тэдний зүгээс санал тавьсан, эсвэл манайхаас санал тавьсан зүйл одоогоор байхгүй.

**-Үндсэн хуулиар Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хумих талаар яригдаж байгаа. Нэр дэвшигч та үүнд ямар байр сууринаас ханддаг вэ?**

Х**.Баттулга:** Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө яригдаж байсан асуудал. Хэрвээ бид Ерөнхийлөгчөө алдах юм бол бидэнд 65 гишүүн, эрх мэдэл байгаа. Их хурлаараа хэлэлцэж байгаад, эрх мэдлийг нь хасна гэсэн зүйл яригдсан юм билээ. Сонгуулийн кампанитынхаа үеэр сонгогчидтойгоо уулзаж байхад ийм асуулт асууж байсан. Монголчууд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын даргыг төрийн гурван өндөрлөг гэж ярьдаг. Ерөнхий сайд ялсан намын олонхиор буюу парламентаар сонгогддог. Харин Ерөнхийлөгч өөрийн гэсэн статустай. Бүх ард түмний саналаар сонгогддог хүний эрх мэдлийг УИХ-аас хасах магадлал нь ямар байдаг юм бол доо.

## М.ЭНХБОЛД: С.Ганбаатарт ямар нэг эргэлзээ байгаа бол хамтраад шалгая



Н.БАТЗАЯА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-аас нэр дэвшсэн М.Энхболд өчигдөр мэдээлэл хийж, байр сууриа илэрхийллээ.

Тэрбээр "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалт өчигдөр орон даяар болж өндөрлөлөө. СЕХ өнөөдөр үдийн үед дүнгээ гаргаж, тайлангаа сонгогчдод тавьсан. Үүнтэй холбогдуулж би нэр дэвшигчийн хувьд мэдээлэл хийх нь зүйтэй гэж үзсэн юм. Юуны өмнө санал хураалтад оролцож, надад саналаа өгсөн сонгогчдод баярласнаа илэрхийлье. Мөн сонгуулийн штабт ажилласан намын идэвхтэн зүтгэлтнүүддээ талархал илэрхийлж байна. Хэдийгээр эцсийн үр гараагүй байгаа хэдий ч би ямар ч үед эдийн засгийн хямралт нөхцөл байдлаас гарах, ард иргэдийнхээ амьдралыг өөд татах асуудалд анхаарал тавьж ажилласаар байх болно.

Сонгуулийн сурталчилгааны ажил эхэлж байх үед би хоёр нэр дэвшигчид хандаж ил захидал илгээсэн. Мөн ёсыг бодож хоёр нэр дэвшигчид алд цэнхэр хадаг хүргүүлж байсан. Энэ сонгуулийг хуулийн дагуу, олон түмнээ хүндэтгэсэн, төрийн хуулийг дээдэлсэн байдлаар явуулъя гэдэг уриалгыг гаргаж байсан. Харамсалтай нь сонгуулийн сурталчилгааны энэ өдрүүд миний уриалсны дагуу болж чадсангүй. Энэ сонгууль гутаан доромжилсон, эвлүүлэг хэрээсээ хэтэрсэн, иргэдийг элдэв зүйлд уриалж дуудсан байдалтай боллоо. Мөн мөнгө тараасан, гадаадаас сая саяар нь хандив авсан сонгууль болж өндөрлөлөө. Би үүнд их харамсаж байна. Тийм ч учраас дараагийн шатны санал хураалт болох нөхцөл байдал руу орлоо гэж дүгнэж байна, би.

Миний талаар янз бүрийн нэвтрүүлэг гарсан. Тэр болгонд би тодорхой тайлбарыг хийсэн. Сонгуулийн сурталчилгааны сүүлчийн өдөр мэтгэлцээн болоход МАН амлалтаасаа яагаад буцсан бэ гэдэг тайлбарыг хангалттай өгсөн. Олон түмэн үүнийг зөвөөр ойлгож байгаа. Мөн миний нэрийг холбогдуулан 60 тэрбумын асуудал гээчийг энэ сонгуулийн үеэр ашигласан. Энэ бол эвлүүлэг гэдгийг хэлсэн. Хууль хяналтын байгууллагуудын гаргасан шийдвэрийг ч тайлбарлаж хэлсэн. Түүнээс гадна газрын наймаачин гэдэг асуудлыг олон жил ярилаа. Үүний талаар хариу тайлбараа бас өгсөн.

Өчигдрийн санал хураалтын хувьд иргэдийн оролцоо, идэвх сайн байлаа. 68 хувийн ирцтэйгээр саналаа өглөө. Өнөөдөр СЕХ хуралдаж, энэ сарын 9-ний өдөр дараагийн шатны санал хураалтыг явуулахаар зарлалаа. Эдийн засгийн нөхцөл байдлаа ч, Үндэсний их баяр наадам дөхөж байгааг ч бодсон долдугаар сарын 9-ний өдөр санал хураалтыг хуулийн дагуу зохион байгуулж, ард түмэн энэ өдөр шийдвэрээ гаргах нь зүйтэй гэж бодож байна. Энэ өдөр иргэд сонгуульдаа идэвхтэй оролцож, саналаа өгөхийг уриалъя" хэмээн хэллээ.

*Түүний дараа сэтгүүлчид зарим зүйлийг тодруулж асуусан юм.*

**-МАХН-аас 30 гаруй мянган саналын зөрүү гарсан. Энэ нь танай намыг сонгууль будилаантуулсантай холбоотой гэж үзэж байгаагаа мэдээлсэн. Энэ тал дээр тайлбар өгөөч?**

-МАХН хэвлэлийн хурал хийсэн талаар мэдээлэл авсан. Сонгууль болгоны дараа МАН руу дайрах явдал өмнө нь олон удаа гарч байсан. Бид аль ч сонгуулийн үед хууль дүрмээ барьж, СЕХ-ноос тавьсан шаардлагуудыг биелүүлж ажиллаж ирсэн. Буруу л бол баруун хойд талын хар овоохой гэдэг шиг бидэн рүү дайрсан, санал луйвардчихлаа гэж хэвлэлийн хурал хийсэн байсан. СЕХ-г шалгая, саналын хуудсыг тоолъё гэдэг санал гаргасан байна билээ. Би үүнийг зөв гэж бодож байна. 30 гаруй мянган саналын зөрүү гарсан. С.Ганбаатарын санал минийхээс 10 гаруй мянгаар илүү байж байгаад яагаад өөрчлөгдчихөв гэдэг дээр эргэлзээ байгаа бол хамтраад шалгасан ч болж байна.

**-Долдугаар сарын 9-нд дахин санал хураалт болоход ирц хүрэхгүй байх юм биш биз. Яагаад үүнээс өмнө санал хураалтыг явуулж болохгүй гэж?**

-СЕХ зүгээр ч нэг энэ өдрийг сонгоод авчихсан биш байх. Хуулиар зохицуулсан цаг хугацаа байгаа учраас л тэр өдрийг сонгосон болов уу гэж бодож байна. Дахин санал хураалт болж байгаа учраас саналын хуудас хэвлэхээс авахуулаад цаг хугацаа шаардана. Багагүй хэмжээний зардал мөнгө гарна. Энэ бүхнээ бодож, тооцож хугацаагаа гаргасан байх. Тийм болохоор баяр наадмынхаа өмнө сонгуулийн ажлаа өндөрлүүлэх нь зүйтэй гэж бодож байна.

## С.ГАНБААТАР: 36 мянган амьгүй албатыг бий болгосон СЕХ-г татан буулга



Б.БОЛОРТУНГАЛАГ

МАХН-аас сонгуультай холбоотой асуудлаар өчигдөр хэвлэлийн бага хурал хийлээ. Хэвлэлийн хуралд Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшсэн С.Ганбаатар, МАХН-ын дэд дарга Ц.Оюунбаатар, УИХ-ын гишүүн асан Ц.Шаравдорж нар оролцлоо. Мэдээллийн эхэнд МАХН-аас СЕХ-г татан буулгахыг шаардаж буйгаа илэрхийлсэн юм. Энэ үеэр УИХ-ын гишүүн асан Ц.Шаравдорж "Юуны өмнө сонгуульд МАХН-аас нэр дэвшсэн С.Ганбаатарт саналаа өгсөн нийт сонгогчиддоо баярлалаа. Та бүхний минь өгсөн санал Монгол Улсын ирээдүйн сайн сайхны төлөө өгсөн санал байлаа. Энэ удаагийн сонгууль Монголчууд луйвар, авлигал хээл хахууль, дээрмийн үнэнг дэлгэж, сэрж сэхээрсний нотолгоо болж чадлаа. Гэвч Хуулийн хүрээнд, хэнээс ч хараат бусаар сонгуулийг зохион байгуулах үүрэгтэй СЕХ сонгуулийг хууль бусаар зохион байгуулж МАН-ын дүнг илүү гаргасан. СЕХ гэмт хэргийн шинжтэй үйлдлийг удаа дараа гаргаж байна. Хууль зөрчиж гаргасан үр дүнг МАХН хүлээн зөвшөөрөхгүй, зөвшөөрөх ямар ч хууль зүйн үндэс байхгүй. Монголчууд төдийгүй дэлхий нийтээрээ энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглалаа. Иргэдийн сонгох эрхийг уландаа гишгиж, Монголын нэрийг дэлхий дахинд гутаасан явдал боллоо. Албан тушаалд шунасан байдал Монгол Улсын нэр хүндийг гутааж байна. СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн шөнө мэдээлэл хийхдээ 1.327.634 хүн санал өгсөн гэж хэлснийг бид бүхэн сонссон. Гэтэл нэр дэвшигч нарын дүнг эцсийн байдлаар мэдээлэхдээ АН-аас нэр дэвшсэн Х.Баттулга 517.478, МАН-аас нэр дэвшсэн М.Энхболд 411.748, МАХН-аас нэр дэвшсэн С.Ганбаатар 409.899 санал авсан гэж мэдээлсэн. Саналын зөрүү гарч байгаа нь сонгуулийн ерөнхий хороо МАН-ын нэр дэвшигчийн талд ажиллаж, сонгуулийг будлиантуулсны нотолгоо" гэлээ. Мөн энэ үеэр Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшсэн С.Ганбаатар "Бид СЕХ-ны мэдээллийг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдэж байна. МАХН-ын олон мянган гишүүд шударга ёсны төлөө тэмцлээ. Эрс шинэчлэлийн төлөө тэмцсэн иргэний нийгмийн байгууллагууд олон жил гадуурхагдсан. Луйврын үр дүнтэй санал нийлж болохгүй. СЕХ 36 мянган амьгүй албатыг бий болголоо. Монголын ард иргэд ээ, тусгаар тогтнол, язгуур эрх ашгийнхаа төлөө шударга бус зүйлийг хүлээн зөвшөөрч болохгүй" гэв. Мөн тус намаас СЕХ-г татан буулгахыг шаардлаа. Учир нь сонуулийн ерөнхий хороо автомат системийг гацааж, сонгуулийн дүнг луйвардахад оролцсон хэмээн МАХН-ын гишүүд үзжээ.

Speak out

# Та ирэх сарын 1-нээс ямар хууль хэрэгжиж эхлэхийг мэдэх үү



Г.ГАНЧИМЭГ

Ирэх сарын 1-нээс албан ёсоор хэрэгжиж эхлэх нэг хууль бий. Тэр нь Зөрчлийн тухай хууль юм. Анх гэмт хэрэгт тооцогдохгүй ч бусдын эрх ашигт сөргөөр нөлөөлж буй зүйлийг зөрчилд тооцож, хуулийн сахилга хариуцлага хүлээлгэхээр хэлэлцэж, бас багагүй улстөржилт, буруу зөрүү ойлголтыг араасаа дагуулж байж эцэст нь нэг юм ойлголцохоо аядаж баталсан билээ, энэ хуулийг. Харин одоо иргэд энэ хуулийн талаар ямар ойлголттой байгаа бол. Бид иргэдийн байр суурь, санал сэтгэгдлийг сонсохын тулд эхлээд “Та ирэх сарын 1-нээс ямар хууль хэрэгжиж эхлэхийг мэдэх үү” гэж асуухад бүгдээрээ “Үгүй” гэдэг товчхон хариултыг өгч байлаа. Арай дөхүүлээд “Гудамжинд шүлсээ хаявал 10 мянган төгрөгөөр торгоно, хүн гүтгэсэн иргэнийг хоёр сая төгрөгөөр торгоно” гэх мэтээр ярихыг сонссон уу” гэхэд “Аан, тийм зурагтаар нэг тийм юм яриад байсан” гээд ам дагуулж байгаад “Ер нь чихнийхээ хажуугаар өнгөрөөсөн” гэдгээ “хүлээн зөвшөөрөв”. Энэ мэтээр манай улсад шинээр төрж буй хуулийн сурталчилгаа хангалтгүй байгаа нь анзаарагдаж байна. Иргэд шинэ хуулийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр бүүр түүрхэн мэдээлэл аваад өнгөрдөг. Харин өөрт нь аль нэг хууль хэрэгтэй болвол боломжтой бүхий л сувгаараа хайж олохыг хичээдэг аж.



## М.Уламбаяр: Торгууль өндөр байх тусмаа хүмүүс хууль хэрэгжүүлнэ

*/Баянгол дүүргийн XXIII хорооны иргэн/*

-Би ойрдоо ажил ихтэй, мэдээ ч үзэх завгүй байсан тул ирэх сарын 1-нээс ямар хууль хэрэгжиж эхлэхийг мэдсэнгүй. Яахав, өмнө нь “Шүлсээ хаявал, хүн гүтгэвэл торгоно” гэх мэт зүйлсийг сонсч л байсан. Яг хэдээр торгох вэ гэдгийг нь мэдэхгүй. Яаж ч бодсон өөрсдийнхөө амьдарч байгаа газар шүлсээ хаяж, бохир заваан байж болохгүй шүү дээ. Мөн хүнийг гүтгэнэ гэдэг бол том хэрэг. Тиймээс энэ хууль нүдээ олжээ. Торгууль өндөр байх тусмаа хүмүүс энэ хуулийг хэрэгжүүлэх болов уу. Бага байвал “Өө, яадаг юм бэ, 10-хан мянга биз дээ” гэдэг байдлаар хандана байх. Хүн амьдарч буй нийгмийнхээ хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж, биелүүлэх ёстой. Гэхдээ шинээр гарч буй хуулийн сурталчилгаа хангалтгүй санагддаг. Ялангуяа ажилтай хүмүүс элдэв зүйл рүү сатаараад байдаггүй. Тэдэнд хуулийн сурталчилгааг хүргэх тохиромжтой хувилбар нь фэйсбүүк, богино долгионы радио санагддаг. Машин барьж яваа ихэнх хүн богино долгионы радио сонсдог шүү дээ. Харин ажил дээрээ богино хугацааны завсарлага авах үедээ сошиалаар ороод гардаг. Тиймээс залхааж ядраахгүй богино хугацаатай хэр нь үр дүнтэй сурталчилгаа байх хэрэгтэй.



## Д.Буянмөнх: Яриа таниулгын аргаар хуулиа сурталчилаасай

*/Баянзүрх дүүргийн XXIII хорооны иргэн/*

-Одоо ямар хууль хэрэгжиж байгаа вэ, ямар нь хэрэгжиж эхлэх вэ гээд мэдэж байгаа юм ер алга. Ямартай ч “Насны хишиг”-ээ авч байгаа. Телевизээр “Нус цэр, шүлсээ хаявал торгоно” гээд ярьж байсан. Түүнийг ямар нарийн ухаж, ойлгох биш дээ. Бүдэг бадаг яриад л өнгөрдөг. Шинээр гарч байгаа хуулийг хүний ой тойнд хүртэл сайн сурталчлахгүй юм. Зарим дүүрэг, хороонд ч шинээр гарч байгаа хууль тогтоомж, дүрэм журмыг иргэддээ ярьж таниулдаггүй. Өөрсдийнхөө хар ухаанаар л хэвлэл мэдээллээс авсан зүйлээ ойлгодог. Ойлгохгүй бол тэгэсхийгээд л орхичидог шүү дээ. Хороо хориндоо иргэд, ахмадуудаа цуглуулаад хуулийн сурталчилгаагаа хиймээр байгаа юм. Бидний үеийнхэн чинь радио сонсох гэхээр чих хатуу, зурагт харах гэхээр хүнээ танихгүй, сонин унших гэхээр нүд бүр харахгүй болчихсон. Тиймээс ойрын зайнаас тулж яриа таниулга хийсэн харилцаанд л дуртай.



## О.Оюунчимэг: Торгуулийн хэмжээ бага байна

*/Хан-Уул дүүргийн V хорооны иргэн/*

-Ирэх сараас ямар хууль хэрэгжиж эхлэхийг сайн мэдэхгүй байна. Гэхдээ гудамжинд шүлсээ хаясан хүнийг торгоно гэж байхыг сонссон. Энэ бол зөв. Эрүүл ахуй, хотын соёл аль ч талаа бодсон энэ нь нүдээ олсон хариуцлагын тогтолцоо. Харин торгуулийн хэмжээ нь арай бага санагдсан. Торгуулийн мөнгө өндөр байх тусмаа хүмүүс айж, хуулиа дагаж мөрдөнө. Мөнгөтэй хүнд багахан хэмжээний торгууль юу ч биш учраас буруу зуршлаасаа салахгүй шүү дээ. Мөн хуулийн сурталчилгаа иргэндээ хэр наалдацтай хүрч байна вэ гэдгийг бодолцох л хэрэгтэй. Ажилтай хүмүүс тэр болгон зурагт үзээд байдаггүй. Нөгөөтэйгүүр, хувь хүн бүр хаана юу болж байна вэ гэдгийг мэдэхийг хичээдэг байх хэрэгтэй. Ялангуяа шинээр төрж байгаа хуулийг анзаарч үздэг байх ёстой гэж би хувьдаа боддог. Харамсалтай нь өнөөдөр аль ч талдаа шинээр гарч буй хуульдаа ач холбогдол өгөхгүй байна. Угтаа бол нэг нь хуулиа сайн сурталчилж, нөгөө нь ойлгож мэдэхийг хичээх хэрэгтэй биз дээ.



## Б.Одгэрэл: Өөрт нь тулгамдсан асуудал болсон хойно л судлах байх даа

*/Сүхбаатар дүүргийн XI хорооны иргэн/*

-Ирэх сарын 1-нд хэрэгжих хууль гээд зурагтаар ярьж байсан. Гэхдээ яг одоо санахгүй байна. Хүн буруу үйлдэл хийвэл заавал хариуцлагаа хүлээдэг байх ёстой. Гудамжинд нус цэрээ хаях, хүн гүтгэх гэдэг асуудал байж болохгүй. Тиймээс зайлшгүй хариуцлагын тогтолцоо байх шаардлагатай юм. Харин нүдээ олсон шийдвэр гаргаж, хуулийн хариуцлагаа зөв хүлээлгэх хэрэгтэй болов уу. Яахав, Монголын нөхцөл байдал, зарим талаар иргэдээ бодож үзмээр санагддаг. Тухайлбал, тэтгэврийн насыг 65 болгосон нь надад таалагддаггүй. Гэтэл өнөөдөр залуучууд үүнийг тоохгүй яваад л байдаг. Эцэст нь тэтгэвэрт гарах гэж байгаа хэдэн хүний асуудал болж хувирч байна. Энэ нь манайд хуулийн сурталчилгаа хангалтгүй байгаагийн нэг жишээ юм. Үүнтэй адилаар өөрт нь тулгамдсан асуудал болж хувирсан хойно л Зөрчлийн хуулийг судлах байх даа, манай залуучууд.



## Н.Цэгмэд: Хэрэгжүүлэхгүй байж хуулиар яах юм бэ

*/Баянзүрх дүүргийн XXIII хорооны иргэн/*

-Шинэ хууль гарлаа гээд амьдрал дээр ямар биелэх биш дээ. Нус цэр, шүлсээ гудамжинд хаяад л байх юм. Ер нь хэрэгжүүлэхгүй байж хуулиар яах юм бэ. Ирэх сарын 1-н гэдэг чинь хаянд тулчихаад байгаа биз дээ. Гэтэл энэ хууль хэрэгжиж эхлэх гэж байгааг мэдэж байгаа хүн байгаа юм уу. Хороонууд хааяа иргэдээ цуглуулж хурал цуглаан хийдэг байх хэрэгтэй. Ахмадууд бол дуртай л очно. Түүн дээрээ хуулиа сурталчилж яриа таниулга хийвэл иргэд илүү ойлгоно байх. Түүнээс биш зурагтаар нэг удаа яриад өнгөрсөн зүйлийг ихэнх нь ойлгохгүй. Нүүр тулж уулзаж байж л мэдэхгүй зүйлээ асууж, ойлгоно биз дээ. Ингэж ажиллавал хэн хэндээ арай илүү үр дүнтэй санагдана.



## Д.Пүрэвхүү: Хуулийн сурталчилгаагаа сайн хий

*/Налайх дүүргийн IV хорооны иргэн/*

-Ирэх сарын 1-нээс ямар нэртэй хууль хэрэгжиж эхлэхийг яг таг мэдэхгүй байна. Харин торгоно, барина гэдэг үгийг бол сонсч байсан шүү. Би хувьдаа гудамж талбайд нус цэр, шүлсээ хаяж байгаа хүнийг торгож, хариуцлага тооцох нь зөв гэж боддог. Яаж ч бодсон энэ чинь эрүүл ахуй талаасаа ч, гурван сая хүнтэй улсын нийслэлийн хувьд ч соёлгүй зүйл. Гудамжинд хаясан нус цэр, шүлс агаар дуслын замаар нийгмийн халдварт өвчин тараана. Тиймээс ухвар мөчид, ухамсаргүй хүмүүстэй хариуцлага тооцож, хэтэвчтэй нь ярих хэрэгтэй. Түүнээс биш бид энэ хуулийн талаар нарийн судалгаа хийж үзээгүй. Ер нь гарч байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэр гээд нарийн нандин бичиг баримт иргэддээ хүрэхгүй байна. Хаагуур, яаж ч явдаг юм бүү мэд. Хуулийн сурталчилгаагаа сайн хийдэг байвал түүн шиг хэрэгтэй зүйлгүй.

# ДЭЛХИЙ

## Амиа алдсан сэтгүүлчийн цогцсыг олжээ

Мексикийн Мичоакан мужийн мөрдөн байцаагчид тавдугаар сард тус мужийн Нуэва Италиа хотын нутаг дэвсгэрт хар тамхины бүлэглэлд хулгайлагдсан Орон нутгийн телевизийн захирал, сэтгүүлч Салвадор Адамын цогцсыг олсноо мэдэгджээ. Одоогоор албаныхан талийгаач сэтгүүлчийг хар тамхины бүлэглэлийн босстой үл ойлголцох асуудал үүссэний улмаас амиа алдсан байж болзошгүй хэмээн үзэж байгаа аж. Мөн цогцсыг хурдны замын ойролцоогоос олсон байна. Албаны эх сурвалжийн мэдээлснээр цогцсыг шатаасан байсан ч, генийн шинжилгээ хийхэд Салвадор Адам сэтгүүлчийнх мөн болох нь тогтоогджээ. Хар тамхины бүлэглэлтэй холбоотой гэмт хэргийн гаралт өндөртэй Мексикт сэтгүүлч амиа алдсан тохиолдол он гарснаас хойш зургаа бүртгэгдсэн байна. Харин энэ удаагийнх долоо дахь нь юм. Олон улсын хил хязгааргүй сэтгүүлчид байгууллагын мэдээлснээр 2016 оны байдлаар Мексик сэтгүүлчдэд халтай орнуудын жагсаалтын гуравдугаарт бичигдэж байжээ. Мекчикийн өмнө Сири, Афганистан нэрлэгдэж байна.

## Д.Трампын цагаачлалын хориг хэрэгжих боломжтой болов

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын аялалын хоригийн саналыг дээд шүүх дэмжих шийдвэр гаргажээ. Түүнчлэн Цагаан ордны цагаачлалын асуудалтай холбоотой хоригийг тодорхой нөхцөлийн хүрээнд дэмжихээр болсон байна. Дээд шүүх тус шийдвэрийг хүчинтэй үлдээх эсэх талаар аравдугаар сард дахин авч хэлэлцэхээ мэдэгдсэн. Дональд Трамп муслим шашинтай Иран, Ливи, Сомали, Судан, Сири болон Йемен гэсэн зургаан орны иргэдийг 90 хоногийн хугацаагаар, цагаачлагчдыг 120 хоногийн хугацаагаар АНУ руу аялаж жуулчлахыг хориглох санал оруулсан юм. Үүнтэй холбоотойгоор тэрбээр улс оронд нь аюул учруулж болзошгүй хүмүүсийг АНУ-д нэвтрүүлэхгүйгээ мэдэгдэж байсан. Түүнчлэн дээд шүүх саналыг зөвшөөрсөн тохиолдолд 72 цагийн дотор шийдвэрийг хэрэгжүүлж эхлэхээ цохон тэмдэглэжээ. Харин дээд шүүхийн холбогдох албаныхан өчигдөр мэдэгдэл хийж, АНУ-ын иргэнтэй гэр бүлийн холбоотой иргэдэд тус хориг хамаарахгүй болохыг тайлбарласан байна.

# СИРИ ДАХИН ХИМИЙН ЗЭВСЭГ АШИГЛАХААР ЗЭХЭЖ БАЙНА




**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Дөрөвдүгээр сард босогчдын хяналтад байгаа Сирийн баруун хойд хэсгийн Идлиб мужид Сирийн цэргүүд мэдрэлд нөлөөлдөг хүчтэй химийн зэвсэг хэрэглэсний улмаас наад зах нь 58 хүн амь үрэгдсэний 11 нь хүүхэд байсан юм. Мөн 500 гаруй хүн хордсон байдаг. Харин үүний хариу болгон Сирийн агаарын цэргийн хүчний баазад АНУ-ын тэнгисийн цэргийн хүчнийхэн Ерөнхийлөгч Д.Трампын тушаалаар далавчит пуужингаар цохилт өгсөн юм. Тухайн үед эх сурвалжууд өөр өөр мэдээлэл хүргэж байсан бөгөөд зарим нь Башар Ассадын тал химийн зэвсэг ашигласан гэсэн бол зарим нь ОХУ-ын байлдааны онгоцууд уг зэвсгийг ашиглан довтолсон гэж мэдээлж байсан. Гэсэн ч, Сири болон ОХУ-ын аль аль нь энэ мэдээллийг няцааж, оролцоогүй гэдгээ мэдэгдсэн байдаг.

Сирид ажиллаж байгаа Хүний эрхийн ажиглагчдын мэдээлснээр хүмүүсийн амьсгал бачимдаж, ухаан алдаж, мөн зарим хүний амнаас хөөс сахарч байжээ. Идлиб мужийн Эрүүлийг хамгаалах албаны дарга Мунзер Халилийн хэлснээр зарин, эсвэл хлор ашигласан гэж үзэж байгаагаа Ройтерсийн сурвалжлагчид хэлсэн байсан юм.

Ямартай ч, энэ тохиолдол нь 2013 оноос хойшхи химийн зэвсэг ашигласан хоёр дахь тохиолдол болж байгаа. Харин АНУ-ын Цагаан ордны мэдээлэл үнэн бол Сири гурав дахь удаагаа химийн зэвсэг ашиглах бололтой. Гэхдээ болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор АНУ-ын зүгээс Сирийн Ерөнхийлөгч Башар ал Ассадад “Дахин химийн зэвсэг ашиглан дайралт хийвэл хатуу арга хэмжээ авах болно” гэдгээ анхааруулсан байна.

Хэвлэлийн төлөөлөгч Шон Спайсер мөн АНУ Исламын хэт даврагч “Лалын улс” бүлэглэлийг устгах зорилгоор Сирид үйл ажиллагаа явуулж буй хэмээгээд “Ассад химийн зэвсэг ашиглан хүн төрөлхтний эсрэг гэм нүгэл үйлдвэл, тэр болон түүний цэргийнхэнд хатуу хариуцлага ногдуулах болно” гэсэн байна. Энэхүү мэдээллийг ч Сирийн Засгийн газар үгүйсгэж байгаа. Гэсэн хэдий ч, АНУ-ын Батлан хамгаалахын төрийн нарийн бичгийн дарга Жэймс Маттис Сирийн цэргийнхэн Иблибын Хан Шейхунд химийн зэвсэг ашигласан нь эргэлзээгүй гэдгийг онцоллоо. Үүнээс гадна Израйлын арми ч Ассадын дэглэм одоо ч хэдэн тонноор хэмжигдэх химийн зэвсгийг нөөцөлж байгаа гэх судалгаа шинжилгээний дүнг нэгтгэн мэдээлсэн аж. Энэ мэтээр Сирид дахин химийн зэвсэг ашигласан тохиолдол гарвал АНУ-ын тал үг дуугүй хариу арга хэмжээ авна гэдгээ хатуу анхааруууллаа. Гэвч, үүнтэй холбоотойгоор Сирийн Засгийн газартай ойр харилцаатай байдаг ОХУ болон АНУ-ын Засгийн газрын хоорондын харилцаа улам хурцдаж магадгүй байгааг “BBC” агентлаг уламжиллаа. ОХУ-ын тухайд 2015 оноос хойш терроризмын эсрэг тэмцэлд нэгдэн, Ассадын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх болсон. Харин АНУ Сирийн Засгийн газрыг урьдын адил олон улсын хууль дүрмийг зөрчиж байна хэмээн буруутгаж буй бөгөөд саяхан гэхэд Сирийн байлдааны онгоцыг буудаж унагасан удаатай. Сирид зургаан жил үргэлжилж буй дотоодын иргэний дайны улмаас 300 мянга гаруй хүн нас барж, таван сая орчим хүн орон гэрээ орхин дүрвэжээ.

## НАЙМАН НАСТАЙ ОХИН “НӨЛӨӨ БҮХИЙ 25 ЭРХЭМ”-ИЙН ЖАГСААЛТАД БАГТЖЭЭ



АНУ-ын “Time” сэтгүүл “Интернэт орчин дахь хамгийн нөлөө бүхий 25 эрхэм”-ийн жагсаалтыг гаргажээ. Тэрхүү жагсаалтад иргэний дайны хөлд нэрвэгдэж, эдүгээ ч мөргөлдөөн үргэлжилсээр байгаа Сирийн Алеппо хотын үнэн нүүр царайг твиттер сүлжээнд цацсан найман настай охин багтсан байна.

“Time” сэтгүүл 2015 оноос хойш жил бүр цахим сүлжээн дэх хамгийн нөлөө бүхий эрхмүүдийг тодруулах болсон бөгөөд өнөөдрийг хүртэл АНУ-ын экс Ерөнхийлөгч Барак Обама, нэрт дуучин Бейонсе нар сонгогдож байсан юм. Харин энэ жилийн нөлөө бүхий 25 эрхмийн нэрсийг зарлалаа. Үүнд Сирийн найман настай Бана Алабед охин сонгогдсон нь дэлхийн хэвлэл мэдээллийн анхаарлыг татаж байна. Бана Алабед охин өнгөрсөн жилийн арванхоёрдугаар сар хүртэл мөргөлдөөн үргэлжилж байсан Сирийн Алеппо хотын зүүн этгээдийг агаараас бөмбөгдсөнөөр хот, гудамж нь сүйрч, дотны найз нь амиа алдсан тухай твиттер хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлж, дотоодын дайныг зогсоохыг уриалж байсан юм. Түүнчлэн, охин АНУ-ын шинэ төрийн тэргүүн Доналд Трампт захидал бичиж, Туркийн Ерөнхийлөгч Ресеп Тайип Эрдогантой уулзаж байсан удаатай. Харин одоогоор охин хөрш зэргэлдээ Турк руу дүрвэн амьдрах болсон бөгөөд эдүгээ түүний твиттер сүлжээ дэх дагагчдын тоо 360 мянгыг давсан байна.

Охин хамгийн сүүлд энэ сарын 20-ны дэлхийн дүрвэгсдийн өдрөөр твиттер хуудастаа дүрс бичлэг нийтэлж, “Өнөөдөр дэлхий дахинаа маш олон хүн өөр нутагт дүрвэн амьдарч буй гэдгийг битгий мартаарай. Амьдрах гэр, эмнэлэг, ажил ч үгүй дүрвэгсдийн дүр зургийг төсөөлөөд үзээрэй” хэмээн англи хэлээр уриалсан байв. “Time” сэтгүүл охиныг яагаад нөлөө бүхий эрхмүүдийн жагсаалтад багтааснаа тайлбарлахдаа “Маш цөөхөн сэтгүүлчдын хүрч очсон Алеппо хот дахь Сирийн иргэний дайны зүрх зүсэм нөхцөл байдлыг таниулсан. Улмаар түүний мэдээлэл өргөн хүрээг хамарч, Сирийн хүүхдүүдийн бэлгэдэл болж чадсан” учир түүнийг энэ жагсаалтад багтаажээ.

## БНХАУ-д тарвасны халдварт өвчин гарчээ

Хятадын хэвлэлүүдэд бичсэнээр, дэлхийн 10 том боомтын нэг Нинбо хотод тарвасны өвчин тархаж, аюулын харанга дэлдээд байгаа ажээ. Өнгөрсөн амралтын өдрүүдэд Хятадын Нинбо хотод “SK5” хэмээх шинэ төрлийн халдвараар гурван хүн нас баржээ. Манай улсын тарвасны импортын 60 гаруй хувь урд хөршөөс орж ирдэг тул иргэддээ анхааруулж байна. Өнөөдрийн байдлаар, Хятадын эрүүл мэндийн байгууллагууд тарвасаар дамжин тархаж байгаа шинэ өвчний шинж тэмдэг, хор хөнөөл, шалтгаан нөхцөл, эмчилгээний талаар ямар ч мэдээлэл өгч чадахгүй байгаа аж. Мөн Далянь хотод 3167 хүн уг халдвараар өвчилж, нас барагсдад яаралтай тусламж үзүүлж байсан эмч нарыг тусгаарлан эмчилж эхэлжээ. Эх сурвалжийн мэдээлснээр, Хятадын зүүн мужийн фермүүдэд тариалсан тарвас нэг нэгээрээ хагарч эхэлсэн бөгөөд хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд учрыг нь тайлбарлаж чадахгүй байгаа юм байна. “Синьхуа” агентлагийн мэдээлснээр, Жинсу мужийн уг тосгонд жимс, жимсгэнэ тариалдаг 20 ферм байдгаас 10-д нь дээрх явдал тохиолджээ.

## Бразилын Ерөнхийлөгчид ял тулгалаа

Бразилын Ерөнхийлөгч Мишель Темерт тус улсын Ерөнхий прокурорын газар авлига, хээл хахууль авсан хэргээр ял тулгажээ. Түүнийг томоохон махны үйлдвэрийн эзнээс авлига авсан гэх хэрэгт буруутгаж байсан ч Ерөнхийлөгч няцааж байсан юм.

Ерөнхийлөгчид тулгасан ялыг Дээд шүүхийн шүүгчид хүргүүлсэн бөгөөд одоо парламентын доод танхим руу шилжүүлэх эсэхийг шийдэх юм байна. Парламентын доод танхим руу хэргийг шилжүүлсэн тохиолдолд тэд санал хурааж, Ерөнхийлөгч Темерийг мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх эсэхийг шийдэх юм.

Мишель Темер гэм буруугүйгээ удаа дараа мэдэгдсээр ирсэн. Түүнийг өнгөрсөн жил албан үүргээ хүлээн авснаас хойш олон хэрэгт буруутгаж байсан ч энэ удаагийнх албан ёсноор ял тулгасан анхны тохиолдол болж байгаа юм. Өмнө нь махны үйлдвэрийн дарга Жосли Батистатай авлига, хээл хахуультай холбоотой асуудлаар зөвлөлдөж байгаа дуу хураагуурын бичлэг олонд дэлгэгдэж байсан.

Үүнтэй холбоотойгоор түүнд тулгах ял нэмэгдэж болзошгүй байгааг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд онцолж байна. Ерөнхийлөгч Темер Бразилын ард иргэдийн дунд нэр хүнд муу байгаа ч түүний барууны төвч нам улс орноо удирдсаар байгаа бол сөрөг хүчнийхэн Ерөнхийлөгчид итгэл хүлээлгэх эсэх талаар санал хураалт явуулахыг шаардаж байгаа юм.

MMINFO.
Тал нутгийн цахим мэдээлэл

## УЛС ТӨР

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА




*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

# Э.ЭРДЭНЭЖАМЪЯН: МАХН ГУРАВ ДАХЬ ШАТНЫ СОНГУУЛИЙГ ЗАРЛАХ ХҮРТЭЛ ТЭМЦЭХ БОЛНО

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

*МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Э.Эрдэнэжамъянтай Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтын дүнгийн эргэн тойронд болж өнгөрсөн үйл явдлын хүрээнд ярилцлаа.*

**-Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгууль шударга болсон эсэхэд ард түмэн эргэлзэж эхэллээ. Ард түмэн МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар 11 аймагт ялалт байгуулж, авсан саналынхаа тоогоор МАН-аас нэр дэвшигч М.Энхболдоос 10 мянгаар илүүрхэж явснаа санал тоолох систем хоёр удаа гацахад л “идэгдэж” гуравдугаарт эрэмбэлэгдсэнд дургүйцэж эхэлсэн. Энэ үйл явц өөрөө Монголын төр хэн эрх мэдэлтэй байна түүнд үйлчилдэг болохыг гэрчилж байгаа хэрэг бус уу?**

-МАХН-ыг дэмжиж, манай намаас нэр дэвшсэн С.Ганбаатарын төлөө санал өгсөн Монголын ард түмэндээ юуны өмнө баярлаж байгаагаа хэлэхийг хүсч байна. Таныг манай өрөөнд орж ирэхийн өмнөхөн Монгол Улсын Ерөнхий сайд асан Дашийн Бямбасүрэн гуай надтай ярилаа. Монголын ард түмний хайр хүндэтгэлийг хүлээсэн энэ эрхэм хүн юу гэж хэлсэн бэ гэвэл “МАХН-ыг улс төрийн гуравдагч хүчин гэж боддог байлаа. Одоо харин Монголыг авч явах гурван том намын нэг болтлоо өсч бойжжээ гэж бодох боллоо. Өмнө нь хоёр том нам эрх барьж байна гэдэг байсан бол одоо гурван нам гэж хэлэгдэхүйц боллоо шүү. Та бүхэнд, танай намын гишүүдэд баяр хүргэе” хэмээсэн. Энэ эрхмийн үгийг бид ард түмний санаа бодлын хураангуй гэж ойлгож, хүлээж авсан. Мэдээж луйвар булхай болсон. Үүнийг ард түмэн бие сэтгэлээрээ туулж өнгөрүүллээ. Ард түмэн Далайцэрэн давсан гэж ярьдаг шүү дээ. Үнэхээр тийм. Далайцэрэн давсан. Ноёны бөхийг унагаж болдоггүй хуулийн өмнө бид хүчгүйдлээ. Бүх зүйл ард түмний нүдний өмнө болж өнгөрсөн учраас бидэнд эмээгээд байх зүйл алга. Арга нь барагдаж тэвдэхдээ компьютераа гацааж байгаад л сонгуулийн дүнг өөрчиллөө шүү дээ. Хоёр удаа гацахад л тав таван мянган иргэний саналаар нэмэгдчихэж байсан, М.Энхболдынх. Эцэст нь дүгнэж хэлэхэд, бид салхи наашаа эргэжээ. Цаг өөр болж байгаа юм байна гэдгийг мэдэрлээ. Ер нь бол энэ удаагийн сонгууль хийгээд сурталчилгааны явц хэд хэдэн сэдвийг хамарсныг та бүхэн анзаарсан нь лавтай. Тухайлбал, нэгдүгээрт, хамгийн өргөн хүрээнд яригдсан сэдэв нь Үндсэн хууль байлаа. МАН-ынхан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах гэж албан ёсоор төсөл боловсруулж, УИХ-д өргөн барьж, бүх ард түмнээр хэлэлцүүлэх гэж оролдлоо. АН-ын нөлөө бүхий хүмүүс Үндсэн хуулийн талаар байр суурьа илэрхийлээгүйсэн бол асуудал тэднийхээр шийдэгдэх байсныг үгүйсгэхгүй. Мөрийн хөтөлбөртөө тусгасан байсан. АН-ынхны тухайд анх удаагаа Оюутолгой, Тавантолгойн гэрээ хэлэлцээрийг зөв зүйтэй тал руу нь оруулна. Ард түмний мэдэлд шилжүүлнэ гэж нэр дэвшигч нь ярьж эхэллээ. АН, МАН-ынхан оффшорыг шалгах хэрэгтэй хэмээн дуугарлаа. Үүнийг нь МАН ажил хэрэг болгож, өрсөлдөгчийнхөө оффшор дансыг сурвалжилж ирээд л олон нийтэд дэлгэлээ. Энэ бүх сэдэв бол МАХН-ын гаргаж тавьсан санаа төдийгүй бидний цаашид баримтлах байр суурь, үзэл санаа юм. Иргэд сонгогч та бүхэн миний хэлсэн бүхнийг эргэж санахыг хүсвэл дээр дурдсан бүхнийг МАХН санаачилж, түүнийгээ ард түмэндээ таниулахыг хичээсэн. Хүссэн хүсээгүй МАН, АН үнэнд гүйцэгдсэн. Хүссэн хүсээгүй энэ хоёр нам МАХН-ын гаргаж тавьсан үзэл санааг хэрэгжүүлэх болно. Тэр хэрээр МАХН хүчирхэгжиж, хатуужина. Янз бүрийн сорилт бэрхшээлийг даван туулах л байх. Янз бүрийн явуулга муу муухайтай зөндөө учирлаа. Эцсийн үр дүн ард түмэн МАХН-ыг дэмжиж, бидний талд зогсч байгаа юм байна гэдгийг бид мэдэрсэн явдал. Нөгөөтэйгүүр, МАХН хэний ч нөлөөнд, ямар ч мөнгөний нөлөөнд автаагүй. Хэрэвзээ бид санхүүгийн хувьд хөл дээрээ боссон, санхүүжилт сайтай байсансан бол 50+1 хэмжээний санал авах байсан байж мэднэ. Ийм хэмжээний сонгууль болж өнгөрлөө гэж гэж ойлгож байгаа.

**-Хөдөө, орон нутагт олонхийн саналыг авна гэдэг цаад утгаараа нэг зүйлийг хэлж байгаа байж мэднэ. Санал хураалтын дүнг дэлгэцээр шууд харуулсан эхний хоёр цагт С.Ганбаатар хоёрт эрэмбэлэгдэж байлаа. Зарим аймагт тасархай байсан. Тэр үед хоёр дахь шатны сонгуулийн талаар ямар гаргалгаа хийж байв, нууц биш бол?**

-Хоёр дахь шатны сонгууль болох нь тодорхой болж ирсэн ч бид эцсийн үр дүнг харна гээд л сууцгааж байсан. Яагаад гэвэл иймэрхүү луйвар анх удаа болж байгаа юм биш шүү дээ. Ер нь УИХ-ын болоод Ерөнхийлөгчийн сонгууль болгоны дараа ийм зүйл болдог шүү дээ. Энэ удаад ч ялгаагүй. Гагцхүү МАН-ын хийсэн луйвар бүх хүний нүдэн дээр улаан цайм ил харагдсанд хэргийн учир оршино. Эл хууль бус үйлдлийг нь ард түмэн ойлгосон байх гэж бодож байна. 2012 оны УИХ-ын сонгуулиар С.Удвал сайд дээр яг ийм зүйл болсон юм. Аймгийн төв дээр нэгээр гараад ирсэн байсан. Дүн гарч, олонхийн санал авсан нь тодорхой болоод ирсэн чинь хэдэн сумын саналын дүн ирэхээ больсон. Гэтэл Засаг дарга нь саналын хайрцгаа аваад зугтсан, хар машинаа аваад зугтсан, цахилгаанаа тасалсан хэрэг гарсан. Иймэрхүү арга залиар тэд ялсан байхгүй юу. Шүүхдээд явахаар ялдаг л юм билээ. Яг үүнтэй адилхан. Монголын 21 аймагт сонгуулийн дүн гарчихаад байдаг. Баян-Өлгийн 20 хэсгийн хорооны үр дүн гардаггүй. Ховдын Үеч сум бас таг. Удалгүй санал унших систем гацаад эхэлсэн. Үнэндээ бусад аймгийнх гацсан үед ч ирсээр байсан мөртлөө Баян-Өлгийнх огт ирэхээ больчихож байгаа байхгүй юу. Тэгээд би бүх хүмүүстэй хэлсэн. Маш хурдан, яаралтай гар талоноо ав гэж. Харамсалтай нь тэд нар талоныг нь өгөөгүй. Тодруулж хэлбэл, 22:00 цагт бүх санал авах байрууд үйл ажиллагаагаа зогсоогоод хар машинаас талон авах ёстой юм. Өнөөдрийг хүртэл нэлээн олон газар машин гацсан гээд талоноо өгөхгүй байгаа. Тэгэхээр иймэрхүү зүйл нь өөрөө дээрээс зохион байгуулалттай гэдгийг илчлээд байгаа хэрэг. Магадгүй их мөнгө тараасан, эрх мэдлээр далайлгасан сонгууль болж байгаа нь эхнээсээ тодорхой болж эхэлсэн учраас сонгуулийн үр дүнг харж байя гэсэн байдлаар асуудалд хандсан. Хоёр нам ч ялгаагүй. Гэтэл дүн нь өөрчлөгдөөд ирсэн сүүлийн мөчид МАН ганц хоёр тойргийг барьж байгаад түүндээ зөрүү саналаа шингээсэн. Энэ бол Монгол Улсад хэрэгжиж чаддаг сонгуулийн бохир технологийн нэг л дээ. Харамсалтай нь үүнийг хэн хийдэг вэ гэхээр намууд биш, төрийн алба, сонгуулийн хороо нь хийдэг юм. Өөр боломж байхгүй. Тэр хар машин, программдаа ч байгаа юм биш. Угаасаа сонгуулийг зохион байгуулж байгаа сонгуулийн хэсэг, тойргийн хорооны хүмүүс л хийж байгаа. Харамсалтай байгаа биз. Монголын төрийн албан хаагчид төрийнхөө сонгуулийг ийн будлиулчихаад юу ч болоогүй муухай асуулт тавихгүй байсан байлгүй. Одоо тийм байдалд орсноосоо болоод ичиж үхэх гэж байгаа биз. МАН-ын өөрсдийнх нь санаачилж зохион байгуулсан арга хэмжээ. Зарчим нь ч тийм байсан.

**-Одоо нийгэм МАХН-ын яахыг нэн анхааралтай ажиглаж байгаа нь нууц биш. Та бүхэн ч тавагтай хоолоо бусдад сул тавиад өгөх бодолгүй байгаа биз. Шүүхэд хандах уу?**

-Бид яах вэ, бүх хяналтын үйл ажиллагаа дуусгана. Сонгуулийн хэсэг, тойргийн хороод дээр нэлээд олон будлиан гарсан. Мөнгө тараасан нь баригдсан. Нотолгоо нь бий. Тэр бүх будлиануудыг бүх шатны шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ гэж бодож байгаа. Болсон үйл явдал үнэхээр сонгогчдын саналд нөлөөлөхүйц байвал сонгууль өөрөө дахих ёстой. Жишээ нь МАН нь юм уу, АН нь юм уу мянгаас илүү олон хүнд мөнгө тараасан байвал тэр нь өөрөө гэмт хэрэг байхгүй юу. Яагаад гэвэл сонгогчид манай намд саналаа өгөх байсан ч юм билүү. Саналын тоо 1000-аар зөрөхөд л асуудал тодорхой болно. Иймэрхүү будлиантай зүйлийг шалгуулна гэж бодож байгаа. Дээрээс нь манай намын эсрэг зохион байгуулалттай муухай пи арыг хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан ард түмэнд цацсан. Яагаав өнөө гадны хүнтэй холбоотой 50 сая вонны асуудал. Үнэнийг хэлэхэд, энэ хэрэгт багийн найз нь оролцсон байдаг. Тодруулбал, багийн найз нь хандив өгөх нэрээр гадны хүн дагуулж орж ирээд бичлэг хийгээд гарсан байдаг. Ний нуугүй хэлэхэд, үүнийг сонгуулийн үеэр дэлгэхэд маш хүнд туссан. Тэр үед манай хүн ч бусдын захиалсан зүйл болоод өнгөрлөө гэж мэдээд хэрэлдэж, энэ тэр болж чадаагүй гэнэ лээ. Тэгээд бидэнд болсон үйл явдлын талаар ярьж, “Би хэрэлдэж, муудалцаж чадсангүй. Гэхдээ би найздаа итгэж байна. Та нар минь энэ асуудлыг зохицуулж өгөөч” гэсэн. Тэгээд ч нөгөө хоёр хүн тэр өдрөө онгоцонд суугаад нисчихсэн байдаг. 23-нд шүүх хуралтай гээд нутгийнхаа мянгат, зуутынхаа хурлын саналыг үндэслэсэн. Албан ёсны хурлуудыг хийсэн. Эцсийн бүлэгт хэнийг дэмжих, дэмжихгүй гэдэг нь ард түмэний эрхийн асуудал. Ямар ч шийдвэрийг гаргаж магадгүй. Харин миний хувьд ийм луйвар булхайтай сонгуулийг албажуулаад хүчин төгөлдөр болгохгүй гэсэн байр суурьтай байгаа. Ер нь сонгуулийн бүрмөсөн хүчингүй болтол явах болно гэж бодож байна.

**-Тэгэхээр таныхаар гуравдагч шатны сонгуулийг зарлах ёстой байж таарах нь ээ. Тийм тохиолдолд улс төрийн намууд нэр дэвшигийг шинээр тодруулах ёстой шүү дээ?**

-Тийм хэмжээнд очтол нь бид тэмцэх болно. Чадах ч юм билээ. Яагаад гэвэл ирц хүрэхгүй байж болно. Ирсэн ирцдээ олонхийн санал авахгүй байх хэмжээнд байж болно. Аль ч хувилбараар. Гэхдээ энэ бол миний хувийн л бодол шүү. Намын хамт олон өөр шийдвэр гаргавал түүнийг нь дагахаас өөр арга байхгүй. Би хувьдаа юу гэж хэлэх гээд байна вэ гэвэл бидний өрсөлдөгчид ард түмний санаа сэтгэлд төдийлөн нийцээгүй. Тиймээс гурав дахь шатны сонгууль болох нь тодорхой. Харин улс төрийн намууд сайн хүнийг олох ёстой. Бид ч тэр хүртэл нь явах болно. Төрөөс ч зардал их гарна. Намууд ч их зардал гаргана. Хамгийн чухал нь зөв хүнээ сонгож гаргаж ирж чадаж гэмээнэ ард түмэн хожино. Зөв хүн нь л хэрэгтэй байна. Тэгж чадвал тэрнээсээ хэд дахин илүү төсвийг бид хэмнэж чадна. Хэд дахин илүү мөнгийг буцаж оффшорчдоос татаж чадна. Хоёр нам угаасаа илүүдээ гарсан их мөнгөтэй юм билээ. Тэр бум тэр бумаар нь өөрт нь санал өгөхгүйг мэдсээр байж л мөнгө тараагаад байсан. Илүү дутуу их ч зардал гаргасан байх. Ер нь тэгээд мөнгөтэй нам хэд ч дахин сонгууль хийхээс айхгүй биз.

**-Өөр асуучихаасай гэж бодож байсан зүйл юу үлдэв?**

-Би өмнө нь нэг ярилцлага дээр хэлсэн. Дэндүү увайгүй юм шиг байгаа нь. Иймл нөхцөл байдал үүссчихээд байна.

**-Танаас асуух бас нэг зүйл бол нэр дэвшигчдийн дунд зохион байгуулсан халз мэтгэлцээн. Тоглоомын дүрэм эхнээсээ М.Энхболдын талд үйлчилсэн гэх яриа байгаа. Үүнийг анзаарсан С.Ганбаатар “Сэтгүүлчдийн тавьсан асуулт М.Энхболд бид хоёрт хөнгөн туслаа” хэмээсэн бус уу?**

-Би шударга байх ёстой гэдэг үүднээс тайлбар хийе. Би тэнд нь байсан юм. Бас ний нуугүй хэлэхэд, учиргүй сэтгүүлчид илэрхий М.Энхболдод үйлчилсэн гэж бодохгүй байна. Мэтгэлцээн болохоос өмнө гурван намын төлөөлөл болон ажлын хэсгийнхэн бүх асуултыг шүүгээд, хамгийн олон давтагдсан эхний 20 асуултыг авъя гэж тохирсон байсан. Гэвч М.Энхболдод ирсэн 1000 асуултын 960 нь хувь хүний амьдрал, ар гэртэй нь холбоотой үлдсэн нь газрын наймаа гэсэн асуулт ирсэн Тиймээс урьд нь ярьж тохирсоноороо эхний 20 асуултыг тавьсан хэрэг. Ямар 60 тэрбумаа 60 удаа асуултай нь биш. Тэгж хөөрхий амьтныг хэлмэгдүүлж болохгүй. Тэр бол үнэхээр тийм зүйл болсон. Х.Баттулга дээр найман төрлийн их олон асуулт ирсэн. Хүнд ч асуултууд байсан. С.Ганбаатарын тухайд 1000 асуултынх нь 950 нь сая воноо тайлбарлаач гэсэн байв. Тэгэхээр М.Энхболд, С.Ганбаатар хоёрын хувьд угаасаа асуух зүйл нь цөөхөн байсан гэж ойлгох хэрэгтэй. Магнай дарга ч байсан, МАН-ын ажлын хэсгийн дарга ч байсан. Бидний хувьд иргэдийн ирүүлсэн асуултад цензур тавиад яах юм гэсэн байр сууриас хандсан. Тийм л зүйл болсон. Бид хажууд нь байсан учраас хэвлэл мэдээллээр нөгөө намаа гүтгэж муулаад яах вэ. Үнэндээ М.Энхболд манай Ганбаатар хоёроос өөр асуух зүйл байхгүй л байхгүй юу. Энэ байдлаа МҮОНРТВ-ийнхэн ард түмэндээ ойлгуулж чадаагүйгээс ийм нөхцөл байдал үүссэн хэрэг. Мэдээж МҮОРТВ-ийнхэн өөрсдөө асуултаа зохиосон бол арай ч тийм ирж байхад өнөө багийнх нь найз нь Монголд 23-нд ирж байх жишээтэй. Үүнийг бид шалгуулна. Учрыг нь олно гэж бодож байгаа. Энэ бол мянга байтугай 10, 20, 30, 40 мянган хүний саналд нөлөөлсөн утгагүй явдал. Гэх мэтчилэн ярих олон юм бий. Эрх барьж байгаа хүчнүүд эрх мэдлээ алдахгүйн төлөө хэт их улайрч байгаа. Эрх мэдэлд очихын тулд юу ч хийхээ буцахаас больж байгаа юм байна. Найз нөхдийг нь ашиглаж байна. Гадаадын хүмүүсийг ашиглаж байна. Шүүх цагдаа, хөрөнгө мөнгө ашиглаж байна. Ер нь байж болох бүх арга залийг зүйлийг хэрэглэж байна. Манай нам иймэрхүү үйл ажиллагаанд харьцангүй бэлтгэлтэй байсан учраас цаг тухайд нь арга хэмжээ авч, ямар ч байсан хууль зөрчилгүйгээр бүх асуудлаа цэгцлээд явж ирсэн.

**-Сонгууль дахих нь тодорхой болж, тов нь ч тодорлоо. Магадгүй С.Ганбаатарт саналаа өгсөн сонгогчид одоо М.Энхболдод өгөхийг үгүйсгэхгүй. Эсвэл хэнд ч өгөхгүй гээд хоосон цаас уншуулж мэднэ. Ийм тохиолдолд улс төрийн хүчнүүд нэгдэн нийлдэг жамтай. МАХН ч үүнээс ангид оршихгүй нь лавтай. Харин хэнтэй гэдэг нь хэн бүхний сонирхол татах нь мэдээж?**

-Манай намын нэг онцлог байдаг. Бид нэр дэвшүүлэхдээ ч хэлж байлаа. Нэг л зарчмыг барина гэж. Заавал намынхаа даргыг гээд байгаа юм биш. Монголын ард түмэн хэнийг хүсч хүлээж байна, түүнийг ретингийг харж байгаад л Н.Энхбаяр даргын нэрийг дэвшүүлсэн. Харамсалтай нь СЕХ бүртгээгүй учраас дараагийн хувилбарыг сонгоход хүрсэн. Ард түмний хүсч байсан дараагийн хүн нь С.Ганбаатар болж таарсан. Тэгээд л дэвшүүлсэн. Улс төрийн том хүчний хувьд өөрсдийнхөө, фракц бүлэглэлийнхээ эрх ашиг гэхээс илүүтэй ард түмэнд хэн хэрэгтэй байгаа юм, тэд юуг хүсээд байгаа юм гэдгийг судалж байж нэр дэвшигчийг тодруулсан. Гишүүдээсээ ч асуусан. Аймаг орон сонгуулийн сурталчилгаан дунд явж ирлээ, бид. Хууль зүйн сайд нь яриад байна. Үнэхээр тийм юм бол түүний хилийн чинадад хадгалсан мөнгийг Монголд авч ирэх ажлыг яагаад хийхгүй байгаа юм. Яагаад шүүхэд өгөхгүй байгаа юм. Цагдаад яагаад мэдэгдэхгүй байгаа юм бэ. С.Ганбаатар гэж хүнийг болохоор цагдаад өгөөд л баривчлах гэж оролдоод л. Хэдэн аймаг даган явж, хурал цуглааныг нь зогсоох гэж оролдоод л. Гэр орноор нь очиж, эхнэр хүүхдийг нь айлгаад яваад байдаг юм. Өдөр болгон шүүх дээр дууддаг. Мөн АН бусдын гарал үүслээр их тоглолоо. Өнөөдөр Монголд амьдарч байгаа иргэний үнэмлэхтэй бүх хүүхэд Монгол Улсын иргэн. Тэгэхээр өнөөдөр бид иймэрхүү зүйлээс болж талцаж муудалцаж болохгүй. Үүний эсрэг сурталчилгаа яагаад хийж байгаа юм. Ийм байж яаж улсын Ерөнхийлөгч болох юм. Хэзээ нэг цагт Монголд орж ирсэн хүмүүсийг та нар Казакстан руугаа зайлцгаа гэж хөөх хэрэг үү. Үүнийг яагаад хууль хяналтынхан авч хэлэлцэхгүй байна вэ. Үүнийг авч хэлэлц. Нөгөө талаар М.Энхболд 60 тэрбумын бичлэгийн талаар цагдаагийн газарт очиж тайлбарлахгүй байгаа юм бэ. Яагаад зөвхөн пиарын аргаар тайлбарлаад байгаа юм бэ. Өөрөө яагаад шүүхэд очиж тайлбарлаж боолхгүй гэж. Цагдаа нар яагаад М.Энхболд гэдэг хүнийг дуудахгүй байгаа юм. Ингэж ялгавартай хандаж болох юм уу. Тэгэхээр хууль ёс ярьж байвал гурвууланд нь адилхан хандах ёстой. Дараа нь гурван саяуланд нь шударга хандах ёстой. Тэгэхгүйгээр бид Монгол Улсад шударга ёс, хууль цааз ярихгүй. Хууль , цагдаагийн байгууллагын ажиллаж байгааг харвал эртний Ромын эзэнт гүрэн нуран унаж байх үеийнх шиг. Эсвэл дундад зууны үеийн Европ шиг язгууртнууд нь нэг хуультай, язгууртан бусууд нь нэг хуультай. Ийм хоёр анги үүсгэсэн гэдгийг өнөөдөр хууль цагдаагийн байгууллагынхан ард түмэнд үйлдлээрээ харуулаад байна.

NO STRESS

Урлан

# Энэ жилийн наадмаар зодоглоно оо



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 31
Шөнө 18

Нөгөөдөр
Өдөр 32
Шөнө 16

## Өдрийн зурхай

**ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ УЛААН НОХОЙ ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 04.55-20.55
**Үс засуулбал:** Эд,мал арвижна



*Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.*

ДУУЛГАХ СОНИН

## САЛЬВАДОР ДАЛИГИЙН шарилд эцэг тогтоох шинжилгээ хийнэ

Нэрт зураач, сюрреализмийн томоохон төлөөлөгч Сальвадор Дали 1989 онд 85 насандаа зүрхний өвчнөөр бурхны оронд заларсан юм. Тэгвэл үүнээс 28 жилийн дараа нэрт зураачийн шарилыг булшнаас нь гарган ирж, шинжлээд эцэг тогтоох шинжилгээ хийх шийдвэрийг шүүхээс гаргалаа. 1956 онд Жирона хотод төрсөн, хөзрийн мэргэч Мариа Пилар Абел Мартинез хэмээх эмэгтэй өөрийнх нь эх Сальвадор Далитай 1955 онд явалддаг байсан тухай өмнө нь хэвлэлд ярьж байв.

Түүний эх Антониа тухайн үед Далигийн гэрийн ойролцоох Каталонийн Кадакес хотод гэрийн үйлчлэгчээр ажиллаж байжээ. Антониа хатагтай нэрт зураачтай дотно харилцаатай байсан гэнэ. Энэ тухайгаа ч охиндоо үе үе ярьдаг байсан аж. Ингээд 2015 онд Абел нэрт зураачийн охин мөн гэдгээ батлуулах гэж Испаний шүүхэд хандсан нь өнөөдөр үр дүнд хүрч байгаа юм. Шүүхээс нэрт зураачийн шарилыг булшнаас нь гаргаж, ДНК-ын шинжилгээ авах шийдвэр гаргажээ. Шүүхийн шийдвэрийг давж заалдах боломжтой бөгөөд ингээгүй тохиолдолд долдугаар сард багтаан шинжилгээ хийх гэнэ.

1955 онд Дали 20 жил хамт амьдарсан Гала буюу Елена Диарановтай хэдийнээ гэрлээд байсан юм.



Хэдийгээр Дали энэхүү гэрлэлтээ "төгс хослол" гэж нэрлэдэг байсан ч тэдний дунд хачин жигтэй харилцаа хадгалагдаж байсан гэдэг. Тухайлбал 1998 онд Vanity Fair сэтгүүлд тэдний хооронд уламжлалт бус дурлалын харилцаа байсан, өөр эмэгтэй, эрэгтэй хүмүүс дунд нь байсан тухай бичиж байв. Далигийн үл хөдлөх хөрөнгө Испанид хадгалагдаж байгаа. Хэрвээ Абел охин нь болохоо баталж чадвал нэрт зураачийн үлдээсэн хөрөнгөөс эзэмших эрхтэй болох юм.

### Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

**Ц. Кена**



Төрсний маргааш коридорт ээжүүд ээлж дараагаараа гүн хямралд орсон, өвдсөн, ядарсан бололтой ээлж ээлжээрээ л утсаар ярьж гомдоллон уйлна. Хүүхдүүд ч ээлжлэн уйлалдана. Би ч хүртэл уйлмаар л санагдаж байлаа. Яагаад юунаас болж гэдгээ сайн мэдэхгүй байгаа юмаа бас. Тэгсэн нэг ээж өрөөний үүдний цаана утсаар ярингаа уйлж байна. "Чи миний цагаан бандаашийг орхисон байна шүү дээ. Ий ий ий. Төрсөн намайг орон гаран болсон гэж бодоо юу ий ий ий. Би чамд цагаан бандааш захисан биз дээ ий ий ий" гээд л нусаа шорхийтэл татаад л байсан. Зүгээр л маш их өвдөлтийг давсны дараа хажууд нь нөхөр, ээж, аав нь орж ирж хамт байж чадахгүй болохоор нэг их гомдолт, тунилт, шалтгаангүй явагддаг юм шиг байгаа юм.

FOOTBALL NEWS



### Йоветичыг "Рома" сонирхож байна

Италийн "Интер" клубт харьяалагдаж байгаа Стеван Йоветичыг "Рома" клуб сонирхож эхэлжээ. Өнгөрсөн улиралд "Севилья"-д зээлээр тоглосон түүнийг Испанийн баг авах магадлал маш бага байгаа аж. Тиймээс "Рома" түүнийг худалдаж авах хүсэлтээ илэрхийлсэн юм байна. Өнгөрсөн улиралд тэрбээр нийтдээ 21 тоглолтод оролцож, зургаан гоол оруулж, дөрвөн гоолын дамжуулалт өгсөн аж.

### Вест Хэм Жиру болон Уолкотт нарыг авахыг хүсч байна

Английн "Вест Хэм" клуб нэг хотын баг болох "Арсенал"-аас Оливье Жиру болон Тео Уолкотт нарыг авахыг хүсч байгаа ажээ. "Алхнууд" энэ хоёр тоглогчийн төлөө 50 сая фунт төлөхөд бэлэн байгаа юм байна. Түүнээс гадна "Манчестер Сити"-гийн довтлогч Келечи Ихеаначог "Вест Хэм" авахаар сонирхож байгаа ажээ. Жиругийн хувьд энэ улиралд нийтдээ 29 тоглолтод оролцож, 12 гоол оруулсан юм. Харин Уолкотт 28 тоглолтод оролцож, 10 гоол оруулжээ

### "Барселона" Паулиньогийн төлөө 20-25 сая евро санал болгож байна

Испанийн алдарт "Барселона" клуб Хятадын "Гуанжоу Эвергранд" багт тоглож байгаа Паулиньог авахаар идэвхтэй сонирхож байгаа билээ. Өдгөө 28 настай Бразил хөлбөмбөгчийг авснаар Каталаны багийн хагас хамгаалалтыг тэнцвэржүүлнэ гэж тэд үзэж буй аж. "Барселона" аль хэдийнэ хувь тоглогчтой тохиролцсон бөгөөд Паулиньо ч өөрөө Европ руу буцах хүсэлтэйгээ илэрхийлсэн. "Гуанжоу"-гийн хувьд түүнийг 40 сая еврогоор зарах хүсэлтэй байгаа аж. Харин "Барса" 20-25 саяар авах гэж үзэж буй юм байна.

Нөгөө талаар Хятадын багийн дасгалжуулагч Луис Фелипе Сколари Азийн аваргуудын лигийн плей-оффын тоглолтын босгон дээр гол тоглогчоор алдахыг хүсэхгүй байгаа гэнэ.


УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ "ГАНЗҮҮ" ЭМНЭЛЭГ

УЛАМЖЛАЛТ ЭМЧИЛГЭЭНИЙ ГАН ЗҮҮ НЭГДСЭН ЭМНЭЛЭГ



Манай эмнэлэг дотор 5 цул, 6 сав эрхтэний өвчлөлийг уламжлалт анагаах ухааны таван засалын аргаар эмчилж, 80-аас дээш хувьтай үр дүн үзүүлдэг.

Бид танд:
- Ган болон мөнгөн зүү, цахилгаан зүү
-Ханиур, сам соруул
-Шарлага
-Бумба төөнө засал
-Халуун чулуу, давсан халуун жин засал
-Эмчилгээний цэгэн бариа
-Архи, сүү, сүүлэн тостой бүтэн биеийн бариа зэрэг уламжлалт анагаах ухааны эмчилгээ үйлчилгээ, мэдрэл, харшил, хүүхэд, эмэгтэйчүүдийн оношлогоо эмчилгээг цогцоор нь хийж үйлчилнэ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БИД ҮЗҮҮЛНЭ

Холбогдох утас: 9999-5584
9900-2332



Салбар 1 хаяг: Найрсаг Улаанбаатар их дэлгүүрийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Өдрийн эмчилгээ/



Салбар 2 хаяг: III хороолол, 28 дугаар сургуулийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Хэвтүүлэн эмчилнэ/